

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН 2016 ОНЫ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ

/Жилийн эцсийн байдлаар/

УЛААНБААТАР ХОТ
2016 ОН

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН 2016 ОНЫ ЗОРИЛТЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2016.11.25.

№	Агуулга	Зорилтын тоо	Хэрэгжилтийн явц						Хувь %
			100	90	70	50	30	10	
1	ХҮНЛЭГ ОРЧИН - НИЙГМИЙН ХӨГЖИЛ	56	46	8	2	-	-	-	97,5
2	НЭЭЛТТЭЙ ОРЧИН - ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ	50	48	2	-	-	-	-	99,6
3	ТОХИЛОГ ОРЧИН - ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ	21	17	4	-	-	-	-	98,1
4	БАЙГАЛЬ ОРЧИН - НОГООН ХӨГЖИЛ	17	16	1	-	-	-	-	99,4
5	ХЯНАЛТТАЙ ОРЧИН - НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ	36	32	4	-	-	-	-	98,8
Дүн		180	159	19	2	-	-	-	98,6

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН 2016 ОНЫ ЗОРИЛТ

ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЕЛЭЛТ	ХУВЬ
НЭГ. ХҮНЛЭГ ОРЧИН-НИЙГМИЙН ХӨГЖИЛ			
1.1 БОЛОВСРОЛ, СОЁЛ			
<p>1</p> <p>1.1.1. Дүүргийн хэмжээнд “Боловсрол 2013-2016” дунд хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэн, боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалт, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.</p>	<p>1</p> <p>1. Дүүргийн ИТХ-ын 2013 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсрол-2016” дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, хэрэгжилт, үр дүнг тайлагнан ажиллана.</p>	<p>“Боловсрол-2016” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 5 бүлэг, 14 зорилт, 79 үйл ажиллагаа бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулан ажиллалаа. Хөтөлбөрийн хүрээнд багшийн ажлын үзүүлэлтээр индексжүүлэн урамшуулах журмыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 23 дугаар тогтоолоор батлуулсан ба “Сайн хичээл, хүүхэд хөгжүүлэх сайн үйл ажиллагаа”-ны чанар, хүртээмж, үр дүнг хүүхэд нэг бүрийн сурлага-хөгжил-төлөвшлийн ахиц, амжилтаар үнэлэх ажлын хэсгийг Засаг даргын 2016 оны А/402 дугаар захирамжаар байгуулан багш нараа үнэлэх ажлыг зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 14, цэцэрлэгийн 28, нийт 42 багшид 25,5 сая төгрөгийн урамшуулал олголоо. Мөн хүнд нөхцөлд амьдарч буй тусламж дэмжлэг шаардлагатай 7 багшид тус бүр 0,5 сая, түрээсийн орон байранд амьдарч буй 8 багшид өргөө цагаан гэр олгож нийт 19,5 сая төгрөгийн тусламж үзүүлсэн байна. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баруун Сөнд хошууны Монгол цэцэрлэгүүд дүүргийн 33, 173, 124 дүгээр цэцэрлэг, 49 дүгээр сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, харилцан туршлага судаллаа. Мөн ОХУ-ын Буриад Улсын Улан-Үдэ хотын Советский дүүрэг, Саха Улсын</p>	<p>100</p>

			<p>Якутск хотын Хангалск дүүрэгтэй 61, 39 дүгээр сургуулиуд хамтын ажиллагаа тогтоон ажиллалаа. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг БНСУ-ын Гвангжу хотын Чусон, Асан хотын Сүн Чон Хянг, Чонан хотын Дангүг зэрэг сургуулиудад туршлага судлуулсан. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн хотын ажил мэргэжлийн сургуультай хамтран туршлага солилцон "СӨБ-ын асуудал ба шийдэл" форумд дүүргийн боловсролын хэлтэс, эрхлэгч, арга зүйч, багш, төрийн бус өмчийн цэцэрлэгийн төлөөлөл бүхий баг бүрэлдэхүүн амжилттай оролцсноор тус ажлын хүрээнд ӨМӨЗО-ны Баруун Сөнд хошууны Монгол цэцэрлэгийн багш нарын төлөөлөл дүүргийн залуу багш нарын "Ур авьяас" тэмцээнээс туршлага судлахаар ирээд байна.</p>	
	2	<p>2. Дүүргийн боловсролын салбарт гадаадын хөрөнгө оруулалт, улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэгийн материаллаг баазыг бэхжүүлнэ.</p>	<p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд шаардлагатай их засвар, хөрөнгө оруулалтын саналыг холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэн хөрөнгө оруулалт татах чиглэлээр ажиллалаа. Дүүргийн төсвийн 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 23, 24, 50, 72, 117 дугаар сургуулиудын хөдөлмөрийн кабинетийг юнимат брэндийн тоног төхөөрөмжөөр хангалаа. Мөн 172,9 сая төгрөгөөр 5 дугаар сургуулийн софт теннисний талбайн тохижилтын ажил, 50,0 сая төгрөгөөр 24 дүгээр сургуулийн хөл бөмбөгийн талбайн засвар, орон нутгийн хөгжлийн сангийн 47,3 сая төгрөгөөр 17 дугаар сургуулийн урлаг заал, 65,3 сая төгрөгөөр 49 дүгээр сургуулийн биеийн тамирын заалны засварын ажлыг гүйцэтгэлээ. Мөн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Миний өв соёл Монгол бичиг мину" уралдаанд хамт олноороо идэвхтэй оролцсон 23, 49 дүгээр сургуулиудын Монгол хэлний кабинетийг орчин үеийн шийдэлтэйгээр тохижуулсан байна. Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын "Хайлааст" ОНХХ-ийн 48,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 72 дугаар сургуулийн</p>	100

				хичээлийн А байрны зүүн жигүүрийн ашиглагдахгүй байсан 7 ариун цэврийн өрөөг иж бүрэн засварлалаа. Үүнээс нэг ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулан тохижуулсан байна.	
2	1.1.2. Хүн амын нягтрал суурьшил ихтэй, хороодод хүүхдийн цэцэрлэг шинээр барих, хуучин цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд гэр цэцэрлэг байгуулахыг дэмжих замаар цэцэрлэгт хамрагдалтыг 80 хувьд хүргэнэ.	3	1. Улсын төсвийн хөрөнгөөр 8, 16, 18 дугаар хороодод он дамжин хэрэгжиж буй хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг дуусган, ашиглалтанд оруулж үйл ажиллагааг эхлүүлнэ.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 8 дугаар хорооны цэцэрлэгийн барилгын 300,0 сая, 16 дугаар хорооны цэцэрлэгийн барилгын ажилд 1050,0 сая, 18 дугаар хорооны цэцэрлэгийн барилгын ажилд 1094,0 сая төгрөг батлагдсан бөгөөд 8, 16 дугаар хорооны цэцэрлэгийн барилгын ажил дуусч ашиглалтад хүлээлгэн өгч, 8 дугаар хорооны цэцэрлэгт 245, 16 дугаар хорооны цэцэрлэгт 246, 18 дугаар хорооны цэцэрлэгт 247 дугаар авч эрхлэгчдийг томилон улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийг аваад байна. 18 дугаар хорооны цэцэрлэгийн гадна засварын ажил дуусч ханын дулаалгын ажил хийгдэж байна.	100
		4	2. 18 дугаар цэцэрлэгийг шинэчлэн барих ажлыг концессийн гэрээгээр шалгарсан компанитай хамтран эхлүүлнэ.	Дүүргийн 18 дугаар цэцэрлэгийг буулган шинэчлэх ажлын хүрээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч гүйцэтгэгчээр сонгогдсон компани тендерээс татгалзсан байна.	90
		5	3.102 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийг дуусгаж үйл ажиллагааг эхлүүлнэ.	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Асар өргөө” ХХК 102 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд дүүргэлтийн ажил дуусч өнгө шаврын ажил эхлэсэн. Одоогоор санхүүжилт олгогдоогүй тул түр зогсоод байна.	90
		6	4. Дүүргийн гэр хороодын иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд хүүхэд асрах үйлчилгээ, цэцэрлэгийн салбар бүлгийн тоог нэмэгдүүлэх санал санаачлагыг бүхий л талаар дэмжин ажиллана.	Орон нутгийн хөгжлийн сангийн 108,5 сая, дүүргийн төсвийн 230,0 сая нийт 338,5 сая төгрөгөөр 124 дүгээр цэцэрлэгт 100 хүүхдийн ортой нэмэлт бүлгийн барилгын ажил дуусч ашиглалтад хүлээн авахад бэлэн болсон. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн 124,4 сая, дүүргийн төсвийн 30,0 сая нийт 154,4 сая төгрөгөөр 154 дүгээр цэцэрлэгт 50 хүүхдийн хүчин чадалтай нэмэлт бүлгийн байр, Орон нутгийн хөгжлийн сангийн 125,0 сая, дүүргийн төсвийн 40,0 сая нийт 165,0 сая	100

			<p>төгрөгөөр 174 дүгээр цэцэрлэгт 50 хүүхдийн ортой нэмэлт бүлгийн байрыг тус тус байгуулан ашиглалтад оруулаад байна. 2015-2016 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийг түшиглэн цэцэрлэгт хамрагдаагүй байгаа 5 настай 142 хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол нөхөн олгох “Нэг гараа-Тэгш боломж” төслийг 2 сарын хугацаанд хэрэгжүүлжүүлэн ажилласнаар дүүргийн хэмжээнд 5 настай бүх хүүхдээ сургуульд бэлтгэж чадсан бол энэ хичээлийн жилд тус төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 282 хүүхдийг хамруулж байна. Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлтэй, бүртгүүлсэн 120 иргэнд нэгдсэн ойлголт өгч мэдээлэл хийлээ. Хүүхэд харагчийг бэлтгэх 40 цагийн тусгай сургалтыг 3 удаа зохион байгуулж дүүргийн хэмжээнд нийт 87 иргэнийг хамрууллаа. Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, иргэдийн хүсэлтийн дагуу үйлчилгээ эрхлэх ажлын байртай нь танилцаж, засаж сайжруулах, анхаарч ажиллах зөвлөмжийг өгч нийт 10 байранд 28 хүүхэд харагчид зөвшөөрлийн гэрчилгээ олгоод байна. Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвөөс дээрх газруудад байнга хяналт тавин ажиллаж байна.</p>		
3	1.1.3. Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар шаардлагатай хороодод ерөнхий боловсролын сургууль шинээр байгуулах, хичээллэх ээлжийн тоог бууруулан, анги дүүргэлтийг стандарт түвшинд ойртуулна.	7	1. Дүүргийн хүн амын нягтаршил ихтэй 12, 16, 17 дугаар хороонд баригдаж байгаа бага сургууль, цэцэрлэгийн цогцолборыг ашиглалтад оруулж үйл ажиллагааг тогтмолжуулна.	12 дугаар хороонд баригдаж буй бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ашиглалтанд орж үйл ажиллагаа эхлэсэн бол 16, 17 дугаар хороодын бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажил дуусч улсын комисс хүлээн аваад байна.	100
		8	2.Төр хувийн хэвшлийн түншлэл, төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааны хүрээнд баригдах цэцэрлэг, сургуулийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтад 7, 9, 17 дугаар хороодод бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 24, 50 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын ажил батлагдсан.	90

4	1.1.4. Сургууль, цэцэрлэгийн орчныг “Хамгаалалттай тусгай бүс” болгон хүүхэд багачуудын аюулгүй байдлыг хангана.	9	1. Дүүргийн сургууль, цэцэрлэгийн орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган хурд сааруулагч, замын тэмдэг тэмдэглэгээ тавих, явган зам, гарц болон авто зогсоолын тоог нэмэгдүүлэх, эцэг эхийн эргүүл хяналтыг тогтмолжуулна.	“School police” хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн орчимд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх ажлыг сурагчийн эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотойгоор зохион байгуулж байна. Тус ажилд 24500 гаруй эцэг эх хамрагдаж гэмт хэргийн шинж чанартай 18 үйлдлийг таслан зогсоож холбогдох байгууллагад мэдэгдэн ажилласан байна. Дүүргийн харъяа төрийн өмчийн 12 сургууль, 23 цэцэрлэг, 16 ӨЭМТ-ийн дунд 2016.02.25-наас 2016.03.29-ний хооронд “Осол гэмтлээс урьдчилан сэргийлье” аяныг нийт 9114 хүүхэд, 5123 эцэг эх, 184 багш ажилчид, 755 иргэдийг хамруулан зохион байгуулсан. 7 буудлаас Чингэлтэй чиглэлийн зам засвар, шинэчлэлийн ажлын хүрээнд 37 дугаар сургууль, 103 дугаар цэцэрлэгийн ойролцоох замд гэрлэн дохио, явган хүний гарц, хурд сааруулагч, явган зам, авто замыг тусгаарласан хашлагатай болгон тохижууллаа.	100
5	1.1.5. “Цахим сургууль, Цахим цэцэрлэг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургуулиудын дэргэд эцэг эх, багш сурагчдад зориулсан “Мэдээллийн төв”-үүдийг байгуулна.	10	1. Дүүргийн ИТХ-ын 2014 оны 79-р тогтоолоор батлагдсан “Цахим сургууль, цэцэрлэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, үр дүнг тайлагнан ажиллана.	Хөтөлбөрийн хүрээнд нийт 75,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ. Үүнд: 17, 72 дугаар сургуулиудийг өндөр хурдны интернетийн шилэн кабельд холбож дотоод сүлжээг шинэчлэн засварлаж анги, танхим бүрийг интернетэд холбогдох нөхцөл боломжийг бүрдүүлээд байна. Мөн дүүргийн төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 43, 74, 108, 154, 155 дугаар цэцэрлэгүүдийг камержуулах ажлыг зохион байгуулж байна. “Пи Ар Си” ХХК-тай хамтран дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн 10 сургуулийг албан ёсны цахим хуудаатай болголоо. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургуулийн байгалийн ухааны кабинетад 100 ширхэг Led дэлгэж олголоо.	100
6	1.1.6. Мэргэжлийн боловсрол, иргэний боловсрол олгох албан бус	11	1. Бичиг үсэг үл мэдэгч, боловсролгүй, сургууль завсардагч хүүхэд, иргэдийн судалгааг	Дүүргийн хэмжээнд сургууль завсардсан хүүхдийн судалгаагаар 35 хүүхэд илэрсэн бөгөөд эдгээр хүүхдийг сургуульд хамруулах ажлыг зохион байгуулж	100

	<p>сургалтын үйл ажиллагааг дэмжин, төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлнэ.</p>		<p>шинэчлэн гаргаж, боловсрол олгох сургалтад хамруулах, төгсөгчдийн мэдлэгийг нэмэгдүүлнэ.</p>	<p>22 хүүхдийг боловсрол олгох сургалтанд хамрууллаа. 2015-2016 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрөөр холимог бүлэгт 80, суурь боловсрол эзэмших 40, ахлах бүлэгт 72 нийт 192 хүүхэд суралцаж байсан бол 2016-2017 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрөөр холимог бүлэгт 91, суурь боловсролд 30, бүрэн дунд боловсролд 89 нийт 210 суралцагч суралцаж байна. Мөн амьдрах ухааны сургалтанд 340, гэр бүлийн боловсрол олгох сургалтанд 150, иргэний боловсрол олгох сургалтанд 60, ёс зүйн боловсрол олгох сургалтанд 30, гоо зүй боловсрол олгох сургалтанд 60 нийт 550 насанд хүрэгчдийг хамруулж байна. Энэ онд суурь боловсрол 40, бүрэн дунд боловсролд 40 нийт 80 хүүхдэд эзэмшүүлсэн байна.</p>	
7	<p>1.1.7. Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэн, хүүхдүүдэд Монгол уламжлал, ёс заншлаа дээдэлсэн зөв хүмүүжил олгоно.</p>	12	<p>1. Дүүргийн ИТХ-ын 2014 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, үр дүнг тайлагнан ажиллана.</p>	<p>“Зөв Монгол хүүхэд”, “Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих” хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд “БИ МОНГОЛ ХҮҮХЭД УРАЛДААН”-ыг 3 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж, 13 сургуулийн 10000 гаруй хүүхэд хамрагдсан байна. Монгол цэргийн өдөр, Эх орончдын өдрийг угтан ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Эх орон-Тусгаар тогтнол” сэдэвт эссэ бичлэг, ном бүтээх уралдааныг зарлан хэрэгжүүллээ. Монгол цэргийн өдрийг угтан ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг спортын “Дөл” тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгуулж, 12 сургуулийн 420 сурагч хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдснөөс 39 дүгээр сургуулийн баг тамирчид тэргүүн байранд шалгарсан байна. Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих зорилгоор 2015-2016 оны хичээлийн жилд “Бид бүгдээрээ тамирчин” төслийг хэрэгжүүлэн ажиллалаа. Энэхүү төслийн эхний шатны шалгаруулалт цэцэрлэг тус бүрт зохион байгуулагдаж шалгарсан 32 багийн 1500 гаруй хүүхэд багачууд дүүргийн шатны шалгаруулалтад</p>	100

			<p>авхаалж самбаагаа сорьсноос шилдэг 9 номинацыг шалгаруулан шагнаж урамшууллаа. Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилтай уялдуулан 2015-2016 оны хичээлийн жилд сурлага, урлаг, спорт, олон нийтийн ажилд манлайлан суралцсан шилдэг 100 сурагчийг урамшууллаа. 2016 оны Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээний хүрэл, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний хүрэл медальт 1 иргэнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 500,0 мянган төгрөгийн урамшуулал олгов.</p>	
	13	<p>2. Дүүргийн Соёлын төвийн дэргэд хүүхэд, ахмад, ардын авъяастнуудын хамтлагийг байгуулан үйл ажиллагааг дэмжин ажиллана.</p>	<p>Дүүргийн Соёлын төвийн дэргэд ахмадын “Дөрвөн цаг” хамтлагийг байгуулан 7 хоногт 1 удаа бэлтгэл сургуулилт хийж урын санг баяжуулах, чанаржуулах ажлыг зохион байгуулж байна. Мөн хөгжим, бүжиг, дууны дугуйланг хичээллүүлж бүжгийн “Синфони”, хөгжмийн “Хүйд” хамтлагийг байгуулан бэлтгэл сургуулилалт хийх нөхцлөөр ханган үйл ажиллагааг нь дэмжин хамтран ажиллаж байна. Эдгээр хамтлагт нийт 50 гаруй гишүүнийг хамруулан ажиллаж байна. 2016 оны 9-р сарын 20,21-нд МҮЭСТО-с зохион байгуулсан “Тунамал авъяас” ахмадын ардын урлагийн наадамд Соёлын төвийн дэргэдэх ахмадын “Дөрвөн цаг” хамтлагийн уран бүтээлчид амжилттай оролцож шагналт байрууд эзэллээ. Уртын дуучдын олон улсын анхдугаар наадамд ахмадын "Дөрвөн цаг" хамтлагийн дуучин гишүүд амжилттай оролцлоо. Оросын холбооны улсын Саха Якутаас 13 хүний бүрэлдэхүүнтэй ардын урлагийн “Тирех” хамтлаг хүрэлцэн ирж дүүргийн Соёлын төвийн дэргэдэх ахмадын 4 цаг хамтлагтай хамтарсан тоглолтыг 57 дугаар сургуулийн урлагийн танхимд зохион байгуулсан. Мөн үндэсний их баяр наадмыг тохиолдуулан зохион байгуулагдсан “Дээлтэй Монгол-2016” наадамд оролцлоо.</p>	100

8	1.1.8. Төвлөрсөн дулаан хангамж, цэвэр бохир усны шугамд холбогдоогүй сургууль цэцэрлэгийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	14	1. Гэр хорооллын дахин төлөвлөлттэй уялдуулан 83 дугаар цэцэрлэг, 72, 49 дүгээр сургуулийг бохирын төвлөрсөн системд холбох ажлыг эхлүүлнэ.	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 49 дүгээр сургууль, 83 дугаар цэцэрлэгийн бохирыг төвлөрсөн системд холбох ажлыг “Буурал сутай” ХХК гүйцэтгэсэн бол 72 дугаар сургуулийн бохирыг төвийн системд холбох ажлыг “Асар өргөө” ХХК гүйцэтгэсэн байна.	100
9	1.1.9. Ерөнхий боловсролын сургуулиудыг орчин үеийн шаардлага, стандартад нийцсэн биеийн тамирын заалтай болгон, сургууль, цэцэрлэгийн гадна талбайг ногоон байгууламж бүхий чийрэгжүүлэлтийн талбай болгон тохижуулна.	15	1. 61 дүгээр сургуулийн спорт заалны барилгын ажлыг шалгарсан компани үргэлжлүүлэн барьж дуусгахад холбогдох асуудлаар хамтран ажиллана.	Дүүргийн 61 дүгээр сургуулийн спорт заалны барилгын ажлын үлдэгдэл төсөв болох 277,5 сая төгрөгийг улсын төсөвт батлуулсан. Одоогоор барилгын дотор заслын хийгдэж байгаа бөгөөд санхүүжилт олгогдоогүйн улмаас ажил зогсоод байна.	90
		16	2. Сургууль, цэцэрлэгийн гадна талбайг ногоон байгууламж бүхий чийрэгжүүлэлтийн талбайтай болгох ажлыг үргэлжлүүлэн дуусгана.	Дүүргийн төсөвт шинээр баригдаж буй сургууль, цэцэрлэгийн гадна талбайн тохижилтын ажилд зориулан 470,6 сая төгрөгийг батлуулсан. Энэ ажлын хүрээнд 157,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 224 дүгээр цэцэрлэгийн гадна талбайг бетон суурьтай төмөр хашаа, тоглоомын талбай, ногоон байгууламжтайгаар иж бүрэн тохижуулсан бол 172,9 сая төгрөгөөр 5 дугаар сургуулийн софт теннисний талбайн тохижилтын ажил, 50,0 сая төгрөгөөр 24 дүгээр сургуулийн хөл бөмбөгийн талбайн засварын ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өглөө. Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн гадна ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хамгаалалтыг сайжруулах зорилгоор нөхөн тариалалт хийн, сургууль, цэцэрлэг тус бүрт арчилгаа хамгаалалтын хуваарь гарган ажиллалаа.	100
10	1.1.10. Багш нарын ажиллах нөхцөл, ур чадварыг сайжруулан, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.	17	1. Дүүргийн сургууль, цэцэрлэгийн багш нарын холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэн, мэргэжил, ур чадвар, заах аргыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна.	Багшийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр ӨМӨЗО-ны Баруун сөнд хошууны Монгол үндэстний цэцэрлэгүүдээс бүрдсэн 28 хүний бүрэлдэхүүнтэй баг дүүргийн 33, 124, 173 дугаар цэцэрлэг, 49 дүгээр сургуульд ажиллаж харилцан туршлага солилцсон ба дүүргийн Засаг даргын 2016 оны А/174 дүгээр захирамжаар томилогдсон баг Баруун сөнд хошууны цэцэрлэгийн багш нарын заах арга, уралдааныг шүүж, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион	100

			<p>байгууллаа. “Сайн хичээлийн үйл ажиллагаа, төлөвлөлт” сэдэвт багш нарын дүүргийн зөвлөгөөнийг угтан сургуулийн 3 бүс, цэцэрлэгийн 5 бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулж, 600 гаруй багш нарыг хамрууллаа. Төрийн бус өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, тогооч нарын мэдлэгийг дээшлүүлэх зоригоор “Бага насны хүүхдийн хооллолт” онол, дадлагын сургалтыг 17 хүнд зохион байгуулж, 20 гаруй төрлийн хоолыг норм, стандартын дагуу бэлтгэж сурсан байна. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг БНСУ-ын Гвангжу хотын Чусон, Асан хотын Сүн Чон Хянг, Чонан хотын Дангүг зэрэг сургуулиадаас туршлага судлуулах ажлыг зохион байгууллаа. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Бага насны хүүхдийн хөгжил” сэдэвт сургалтыг цэцэрлэгийн туслах багш нарын дунд зохион байгууллаа. Сургалтанд 23 цэцэрлэгийн 140 гаруй багш хамрагдсан. TV-9 телевизтэй хамтран сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд танин мэдэхүйн “АХА” нэвтрүүлгийг 5 бүсээр, 4 үе шаттай /Багш, хүүхэд, эцэг эх, хамтран ажилладаг байгуулага/ зохион байгуулж 1200.0 орчим хүн хамрууллаа. Мөн Тоглонгоо суралцах арга зүйг дэмжсэн багш нарын сайн туршлагаас бүрдсэн гарын авлага эмхтгэл гаргаж сайн туршлагаа үндэсний түвшинд түгээсэн. Ерөнхий боловсролын сургуульд 12 төрлийн 2494 удаагийн хичээл, үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 24864 багш, удирдах ажилтан, сурагч, эцэг эх, төрийн ба төрийн бус байгууллагын ажилтан албан хаагчдыг оролцуулсан. Мөн 76 удаагийн туршлага солилцлох үйл ажиллагааг зохион байгууллаа. Сургууль, цэцэрлэгийн сургалтын менежер арга зүйч нарт “Багшийн ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт сургалтыг ДЗОУБ-тай хамтран зохион байгуулж 61 хүн</p>	
--	--	--	--	--

			хамрагдсан. Төрийн бус өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, тогооч нарын мэдлэгийг дээшлүүлэх зоригоор “Бага насны хүүхийн хоололт” онол, дадлагын сургалтыг зохион байгуулснаар 17 хүн хамрагдаж 20 гаруй төрлийн хоолыг норм, стандартын дагуу бэлтгэж сурсан байна.	
		18	2. Багшийн ажлын үр дүнг сурагчдын дүнгийн ахицаар урамшуулдаг тогтолцоо нэвтрүүлэн, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.	100
11	1.1.11. Соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, нийтийн соёлыг дээшлүүлэх “Хотын иргэн - Хотын соёл” хөтөлбөрийг	19	1. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын дурсгалт өвүүдийг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах, түүхийн өв соёлыг сурталчлах ажлыг зохион	100

	хэрэгжүүлнэ.	байгуулна.	дурсгалын “Бүртгэл мэдээллийн санг” бүрдүүлэн, баяжууллаа. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын дурсгалуудыг олон улсын музейн өдрийг угтан дүүргийн сайтанд цувралаар мэдээ бэлтгэн танилцуулсан. Мөн энэ өдрийг тохиолдуулан Улаанбаатар хотын музейтэй хамтран Хүннү Молл дахь Гамма галерейд “Чингэлтэй хайрханы өвөрт” гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан. Мөн Улаанбаатарын Их сургууль, Дүрслэх урлагийн музей, Улаанбаатар хотын музейтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллалаа.	
	20	2. Соёл урлагийн талаарх Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, хүүхэд залуусын авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн уралдаан, тэмцээний тоо, чанарыг нэмэгдүүлнэ.	Хүүхэд залуусын авьяас билгийг нээн хөгжүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон, үр ашигтайгаар өнгөрүүлэх зорилгоор дүүргийн соёлын төвийн төгөлдөр хуурын дугуйланд 5, морин хуурын дугуйланд 7, дууны дугуйланд 5, сонгодог болон монгол бүжгийн дугуйлан 23 хүүхэд тус тус давхардсан тоогоор хамрагдсан ба нийт 40 хүүхэд хичээллэсэн. Дугуйлангийн сурагчдаас “Ая эгшгийн 6 жигүүр” өсвөрийн хөгжимчдийн Улсын уралдаанд морин хуурын дугуйлангийн сурагчид оролцлоо. Мөн Бүжгийн дугуйлангийн 2 сурагч Монголд анх удаа зохиогдсон “Wonder baby Mongolia 2016” fashion шоунд түрүүлэн түрүүлэн Шанхай хотноо зохиогдох “Wonder baby kids international fashion” олон улсын хүүхдийн миссийн уралдаанд оролцож насны ангилал тус бүрдээ тэргүүн байр эзэлсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны А/136 тоот тушаалын дагуу “Бидний бахархал” хүүхдийн ардын урлагийн наадмыг 10 дахь жилдээ зохион байгууллаа. Тус наадамд ерөнхий боловсролын 14 сургууль, 15 цэцэрлэгийн нийт 1000 гаруй хүүхэд хамрагдлаа.	100
	21	3. Дүүргийн ИТХ-ын 2014 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан “Хотын иргэн-Хотын соёл” хөтөлбөрийг үргэлжлүүлэн	“Хотын иргэн-Хотын соёл” хөтөлбөрийн хүрээнд “Номтой нөхөрлөө” аян, МҮОНР-ийн “Соён гэгээрлийн цаг” аяны хүрээнд МҮОНР радиотой хамтран “Миний ном-Миний хобби” уралдааныг зохион байгууллаа.	100

		<p>хэрэгжүүлж, үр дүнг тайлагнан ажиллана.</p>	<p>Уралдаанд хүүхэд залуус өөрсдийн уншсан номноос сэдэвлэн эх орноороо бахарсан, өв соёл, ёс заншлаа дээдэлсэн, хүүхэд багачуудын дунд мартагдаж буй ахуйн соёлыг сэргээсэн, эцэг эх, ахмад үеэ хүндэлсэн, орчин цагт хүүхэд багачуудад аюул заналхийлэл учруулж буй олон талт асуудлуудыг тусгасан 50 гаруй родио жүжгийн зохиол ирүүлснээс шилдэг 6 зохиол шалгарч, 4 зохиолыг сонсдог ном болгон CD-нд буулган хэвлүүлж, хүүхдийн номын өргөөнд хандивлалаа. Дүүргийн авъяаслаг гэр бүл шалгаруулах тэмцээнийг ХГБХТ, Соёлын төв хамтран зохион байгуулж, нийт 19 хороодоос авъяаслаг гэр бүлүүд оролцсоноос 13-р хорооны иргэн Т.Сармандахын гэр бүл 1-р байранд шалгарч Нийслэлийн авъяаслаг гэр бүл шалгаруулах тэмцээнд оролцохоор бэлтгэл сургуулилтандаа ороод байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авъяас чадварыг нээх, хөгжүүлэх, соёл урлагаар дамжуулан нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, багаар хамтран ажиллах дадал чадварыг хэвшүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлагийн наадмыг 2016.05.25-ны өдөр зохион байгууллаа. “Өнчин цагаан ботго” хүүхдийн дуулалт бүжгэн жүжгийг 2016.05.31-ний өдөр Улаанбаатар чуулгын тайзнаа тоглолоо. Тус уран бүтээлд Соёлын төвийн уран бүтээлчид, дэргэдэх хамтлагууд, дугуйлангийн сурагчид нийт 40 гаруй уран бүтээлчид оролцсон. Соёл урлагаар дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх, амьдралын нийтлэг соёлыг төлөвшүүлэх, үндэсний соёл урлаг, өвийг сурталчлан таниулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор “Бид сайн сайханд дагуулна” өдөрлөгийг 2016.05.22-ны өдөр Соёл, урлагийн Их сургуультай хамтран зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үеэр Соёл урлагийн их сургуулийн өмнөөс Тусгаар тогтнолын талбай хүртэл 1000 гаруй иргэд парад жагсан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 1000 гаруй хүүхэд багачууд</p>	
--	--	--	---	--

			<p>өөрсдийн бүтээлийн үзэсгэлэн, тоглолтоос үзүүлсэн. Өдөрлөгөөр нийт 10 мянга гаруй иргэнд соёл урлагийн олон талт үйл ажиллагаа, төрийн үйлчилгээ, мэдээ, мэдээлэл хүргэн ажиллалаа. Үндэсний их баяр наадмын өдрүүдэд төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд Соёлын төвийн дэргэдэх ахмадын “Дөрвөн цаг” хамтлаг, Якут улсын Хангалас дүүргийн ардын авъяастан ахмадуудын “Тирех” хамтлагуудын хамтарсан “Ахмадаа хүндэтгэе” тоглолтыг наадамчин олондоо өргөн барилаа.</p> <p>МҮОНР-ын хүүхэд залуучуудын редакциас “Соён гэгээрүүлэгч” төслийн хүрээнд санаачлан хийж байгаа “Номонд багтсан ертөнц” нэвтрүүлэгт Хүүхдийн номын өргөөний номын санчид байгууллагаа сурталчлах зорилгоор хариуцсан давхруудаа дэлгэрэнгүй тайлбарлаж оролцлоо. Нэвтрүүлэг нийт 5 дугаар болж МҮОНР радиогийн эфирт цацагдсан.</p>	
12	1.1.12. Дүүрэгт “Хүүхдийн хөгжлийн төв” шийдвэр гаргах хүүхдийн нэмэгдүүлнэ. байгуулж, түвшинд оролцоог	22	<p>1. Дүүргийн “Хүүхдийн хууль зүйн хороо”-ны үйл ажиллагааг эрчимжүүлэн, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ.</p> <p>Дүүргийн Хүүхдийн хууль зүйн хорооны 4 зорилт, 12 үйл ажиллагаа бүхий ажлын төлөвлөгөө гаргаж Дүүргийн Засаг дарга бөгөөд Хууль зүйн хорооны тэргүүнээр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 72 дугаар сургуулийн сурагчдын өөрөө удирдлагын байгууллагаас санаачлан “Хүүхдийн дуу хоолой” чуулганыг 5 дахь удаагаа зохион байгуулж, сурагчдын төлөөлөл, эцэг эхчүүдийн төлөөлөл, сургуулийн нийгмийн ажилтнууд, Нийслэлийн боловсролын газар, БСШУЯ-ны мэргэжилтнүүд зэрэг 200 гаруй төлөөлөгчид оролцлоо. Чуулганаар сургуулийн түвшинд сурагчдад тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцаж, сургууль, дүүрэг, нийслэлийн хэмжээнд хүүхдэд тулгамдаж буй асуудлыг холбогдох шатны шийдвэр гаргагчдад хүргүүллээ. Дүүргийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутагт хүүхэд хамгааллын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих Ажлын</p>	100

			<p>хэсгийг дүүргийн Засаг даргын А/272 дугаар захирамжаар байгуулан асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоох, хүүхдийн үрчлэлтийн асуудалд хяналт тавих, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын 10 төрлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 400 орчим хүүхэд, 900 гаруй эцэг эхчүүд хамрагдаж хүүхдийг аливаа эрсдэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлийн 2500 гаруй зурагт хуудас, тараах материал, гарын авлагыг эцэг эх, хүүхдүүдэд тараан сурталчилан ажилласан байна. Дүүргийн Засаг даргын 24 удаагийн захирамжаар 31 хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоож, Асрамж халамжийн төвөөс 4 хүүхдийг гэрт нь буцааж, Асрамжийн төвд-5 хүүхдийг асрамжлуулахаар шийдвэр гарсан байна. Хорихоос өөр төрлийн ялтай 6 хүүхдийг хууль эрхзүйн болоод амьдрах ухааны сургалтанд сард 2 удаа хамруулж, хяналт тавьж байна.</p>	
	23	2. Дүүргийн Засаг даргын дэргэдэх “Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв”-ийн барилгын ажлыг эхлүүлнэ.	<p>Хүүхэд хөгжлийн төвийн барилгыг 13 дугаар хорооны хуучин өрхийн эмнэлгийн байрны эзэмшил газар 0,460 га талбай дээр байгуулахаар нийслэлийн Засаг даргын 2014оны А/363 дугаар захирамж гарсан боловч 2016 оны 7 дугаар сарын 8-ны өдөр нийслэлийн Засаг даргын захирамж гарч уг газарт Нийгмийн даатгалын Чингэлтэй, Хайлаастыг хариуцсан тасаг байгуулахаар шийдвэрлэн барилгын ажил явагдаж байна.</p>	90
	24	3. Хороодын Гэр бүл, хүүхэд хөгжлийн танхимын үйл ажиллагааг тогтмолжуулан, хүүхэд хамгааллыг сайжруулах талаар төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	<p>Дүүргийн 6, 9, 10, 11, 14, 15, 16, 18-р хороодод Хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх өрөөг гарган тохижуулж үйл ажиллагаа нь тогтмолжуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын хэлтэс, Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, ДЗМОУБ-ын Чингэлтэй орон нутгийн хөгжлийн төв хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хорт зуршлын хэрэглээ болон үе тэнгийнхний дарамт, хүчирхийллийн хор хөнөөлийн талаар ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, хүүхдийн тусламжийн утас 108</p>	100

			болон хүүхдийн оролцооны талаар зөв мэдээллийг сурталчлах зорилго бүхий “Зөв хүүхэд-Зөв сонголт 2016” дэвжээ тэмцээнийг дүүргийн ерөнхий боловсролын 12 сургуулийн 96 сурагч, багш эцэг эхчүүдийн дунд зохион байгууллаа. Мөн хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн 61 дуудлагад хариу үйлчилгээ үзүүлж, зорилтот бүлгийн 8 хүүхдийг бичиг баримтжууллаа.		
13	1.1.13. Дүүрэгт Соёлын ордон, номын сан байгуулж, хүн амыг номтой нөхөрлүүлэх үйл ажиллагаа өрнүүлнэ.	25	1. Дүүргийн Соёлын төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, шинээр баригдах Соёлын ордны газрын болон хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад санал хүргүүлж шийдвэрлүүлэн ажиллана.	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд дүүргийн 15 хороонд Соёлын ордон барихаар зураг төсвийг боловсруулан холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлээд байна. Соёлын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор дүүргийн төсвийн 29.9 сая төгрөгөөр хөгжим техник хэрэгслээр хангалаа. Дүүргийн Соёлын төв нь 5 төрлийн дугуйланд дүүргийн хүүхдүүдийг хичээллүүлж, ахмадын 4 цаг хамтлаг, бүжгийн Симфони хамтлаг, хөгжмийн Хүйд хамтлагийг дэргэдээ хичээллүүлж байна. Ахмадын “Дөрвөн цаг” хамтлагийн бүжигчид, дуучид 7 хоногт 1 удаа бэлтгэл сургуулилт хийж урийн сангаа баяжуулан, чанаржуулах талаар анхааран ажиллаж байна. Соёлын төв нь “Өнчин цагаан ботго” үлгэрээс сэдэвлэсэн хүүхдийн дуулалт бүжгэн жүжгийг найруулан тавьж, соёлын төвийн уран бүтээлчид, дэргэдэх хамтлагууд, дугуйлангийн сурагчид нийт 40 гаруй уран бүтээлчид оролцлоо.	100
		26	2. Дүүргийн сургууль, цэцэрлэгүүдэд “Номтой нөхөрлөө” аян өрнүүлж, номын сангуудын фондыг нэмэгдүүлнэ.	Дүүргийн хэмжээнд “Номтой нөхөрлөө” аян өрнүүлэн ажилласнаар “Хүүхдийн номын өргөө”-нд 4500 гаруй номын баяжилт хийгдлээ. Энэ аянд цэцэрлэг, сургуулиуд анги хамт олноороо нэгдэн идэвхтэй оролцсон. Тухайлбал, 21 цэцэрлэг нийлж 1100 ширхэг ном хандивласан бол 23 дугаар сургуулийн 11д ангийн хүүхдүүд хэрэгцээт 40 ном хандивлалаа.	100
		27	3. Хүүхдийн номын өргөөний үйл ажиллагааг тогтмолжуулж, сан хөмрөгийг баяжуулна.	Дүүргийн хүүхдийн номын өргөөний үйл ажиллагааг захирал, эрхлэгч, номын санч, фондчин, үйлчлэгч гэсэн бүтэц орон тоотойгоор Орон нутгийн өмчит, аж ахуйн	100

			<p>тооцоот үйлдвэрийн газар болгон өргөжүүлснээр өдөрт 60-70 хүүхдэд үйлчилгээ үзүүлж байна. UBS телевизтэй хамтран Хүүхдийн номын өргөөний сан хөмрөгийг баяжуулах сарын аяныг зарлан хэрэгжүүлж номын сангийн сан хөмрөг 2296 ширхэг номоор баяжигдлаа. Хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, уншигч хүүхдүүдийг цахим үнэмлэхжүүлж, номын каталоогоо цахимжуулж, хүүхдүүдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн номын баяжилт хийн ажиллаж байна. Тайлант хугацаанд Хүүхдийн номын өргөөгөөр үйлчлүүлэгч хүүхдийн тоо 10649 болоод байна. Одоогоор номын өргөөний номын сан хөмрөг 6000-д хүрсэн бөгөөд үүнээс бүртгэж дансалсан номын тоо 3433, хандиваар ирсэн номын тоо 2182 байна. Мөн Номын өргөө цахим номтой болж цахим болон сонсдог 300 гаруй номтой таблет 9 ширхэгийг номын өргөөний үйлчилгээндээ нэвтрүүлээд байна.</p>		
1.2. Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир					
14	1.2.1. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох замаар хүн амын эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлнэ.	28	<p>1. Дүүргийн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулан батлуулж, хороодын иргэний танхимтай хамтран эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн ажиллана.</p>	<p>Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Нэгдсэн төлөвлөгөөний дагуу осол гэмтлээс сэргийлье, архи дан согтуурахаас сэргийлье, охид эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, сүрьеэгийн халдвараас сэргийлье, эрүүл мэндийг дэмжих, ургамлын тоосны харшил, тамхи, хүчирхийллийн эсрэг, гэдэсний халдвараас сэргийлье, хөдөлгөөн эрүүл мэнд, эмийг зохистой хэрэглэе, хүүхэд залуучуудын эрүүл мэнд, ахмад настны эрүүл мэнд, хавдраас сэргийлье, чихрийн шижин зэрэг сэдвээр 2016 оны байдлаар 391 удаагийн сургалтыг 24311 хүнийг хамруулж, 113 төрлийн 44032 ширхэг ЭМ-ийн МСС-ны материал тараасан. Эрүүл мэндийн төвийн хэмжээнд 13 удаагийн өдөрлөг зохион байгуулан нийт 3809 хүнийг хамруулсан. Дэлхийн зөн ОУБ-тай хамтран Эх хүүхдийн эрүүл</p>	100

			<p>мэнд, жирэмсэн эхийг хянах, орчны эрүүл ахуй, ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 30 удаагийн сургалтаар ЭМТ, ӨЭМТ-үүдийн эмч, эмнэлгийн ажилтан, сайн санааны туслагч нарт давхардсан тоогоор нийт 650 хүнийг хамруулж мэдлэг чадвар олгосон. Осол гэмтэл, Архи тамхины хор хөнөөл, Өсвөр үеийн эрүүл мэнд, Улаанбурхан, Халдварт өвчин, Амны хөндийн эрүүл мэнд зэрэг сэдвүүдээр ЕБС, цэцэрлэгийн давхардсан тоогоор 145 эмч, нийгмийн ажилтан, 24000 гаруй хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаа зохион байгуулсан. ЭМТ-ийн веб сайтанд Эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааны 52 нийтлэл нэмж оруулж, цаг үеийн өвчлөлөөс сэргийлэх зөвлөмжийг хүргэсэн. Мөн ЭМТ-ийн төв салбар бусад салбаруудад шинээр 6 төрлийн самбар байршуулж иргэдэд эрүүл мэндийн сурталчилгааг хийсэн.</p> <p>ӨЭМТ-ийн сурталчилгааны 19 дэлгэцээр эрүүл мэндийн цаг үеийн мэдээлэл, урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг нэгдсэн байдлаар явуулж иргэдэд мэдээ мэдээллийг тогтмол өгч ажилласан.</p>	
	29	2. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон, өрх, иргэний тоог нэмэгдүүлэх, эрүүл мэндийг дэмжигч иргэдийн клубын үүсгэл санаачлагыг дэмжин ажиллана.	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрх, иргэн шалгаруулах болзол журмыг дүүргийн 22 цэцэрлэг, 8 ЕБС-ийн эмч, нийгмийн ажилтан, ӨЭМТ, ЭМССТ 85 хүнд сурталчилан мэдээлэл хүргүүлсэн. 2016 оны байдлаар 10 өрхийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийн дэмжигч иргэн, өрхийг шалгаруулж иргэдэд сурталчилан ажилласан.	100
	30	3. Иргэдийн архи, тамхины хэрэглээг бууруулах, зөв дадал эзэмшүүлэхэд чиглэгдсэн иргэдийн сайн дурын клубуудыг хороодод байгуулан, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	Дүүргийн 6-р хорооны “Шинэ алхам” төрийн бус байгууллагын АА цуглаанд 1,2,6-р хорооны архинд донтох эмгэгтэй 120 гаруй иргэд хамрагдан, үйл ажиллагаа тогтмол явагдаж байна. Эрүүл мэндийн төвийн сэтгэц наркологийн кабинетаар үзлэг хийлгэсэн 897 үйлчлүүлэгчээс 67 иргэнд “Тамхины хор хөнөөл”, 15 иргэнд “Архидан согтуурахын хор уршиг” сэдвээр зөвлөгөө өгч, гарын авлага тараасан. “Архи бэлгэнд	100

			<p>өгөхгүй, архи айлд барьж орохгүй” уриатайгаар Хүчит Шонхор зах дээр сурталчилгааны ажлыг зохион байгуулж 1000 гаруй иргэдэд мэдээлэл өгч санамж тараасан. Тамхины утаагүй Улаанбаатар хөтөлбөрийг эрчимжүүлэх дүүргийн Засаг даргын захирамж, ажлын төлөвлөгөөг гаргаж иргэдийн дунд тамхины хэрэглээг бууруулах, тамхинаас татгалзах чиглэлээр ЭМ-ийн МСС, эмнэлгийн орчин 100 хувь тамхигүй орчин арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Хороод, иргэний танхимаар Архи тамхины хор хөнөөлийн чиглэлээр 5 төрлийн гарын авлага тарааж 1465 иргэнд мэдээлэл сургалт сурталчилгаа хийсэн. Хороодын хамтарсан багуудын дундах “Хамтарсан баг хамтын ажиллагаа” 3 сарын аяныг ДЗОУБ, Гэр бүл хөгжлийн төв хамтран зохион байгуулж 13 ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, эцэг эх, хороодын иргэдэд архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн чиглэлээр сургалт сурталчилгааг хийж 15 мянга орчим хүн хамруулсан. ӨЭМТ-үүдэд дэмжлэгт хяналт хийж архи тамхи, сэтгэц идэвхит бодисын хэрэглээг илрүүлэх ASSIST тестийг авах талаар зөвлөгөө мэдээлэл өгч, хялбаршуулсан материалыг тараасан.</p>		
		31	<p>4. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт дүүргийн хүн амын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>2016 оны байдлаар ЗС, Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг 40.5, Чихрийн шижний эрт илрүүлэг 35.4% байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүд Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх зорилгоор 32 удаагийн өдөрлөг сургалт зохион байгуулж зохион байгуулж 4521 хүнийг хамруулсан байна.</p>	100
15	<p>1.2.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эх хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна.</p>	32	<p>1. 2-10 насны хүүхдүүдийн шүд цоорох, 11-18 насны хүүхдийн гүйлсэн булчирхайн архаг өвчнөөс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.</p>	<p>Сайн хөрш олон улсын байгууллагатай хамтран ерөнхий боловсролын 37, 49, 72, 117 дугаар сургуулийн дунд ангийн 2500 хүүхдийг чих хамар хоолойн эмчийн үзлэгт хамруулснаас гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй 950 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн. Мөн 3250 хүүхдэд шүдний үзлэг хийж, амны хөндийн эрүүл ахуй сэдвээр гарын авлага материал тараан, шүд цоорох өвчин илэрсэн 1665</p>	100

			хүүхдээс 652 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн. Дүүргийн эрүүл мэндийн төв, ӨЭМТ-үүд ерөнхий боловсролын 13 сургууль, СӨБ-ын 23 цэцэрлэгт урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж 14000 орчим хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Хүүхдийн салбар амбулаторийн үйл ажиллгааг сурталчлах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн 180 хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж хяналтанд авсан.	
		33	2. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эх хүүхэд, асран хамгаалагч нарт эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт, үзлэг оношлогоог зохион байгуулна.	100
16	1.2.3. Эрүүл мэндийн байгууллагын техник технологийг дэс дараатай шинэчлэн, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, дүүрэгт Яаралтай түргэн тусламжийн пункт байгуулна.	34	1. Дүүргийн эрүүл мэндийн байгууллагын техник, тоног төхөөрөмжийг дэс дараатай шинэчлэн, иргэдэд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	100
			БНСУ-ын “Гүүд нейборс” ТББ-ын дэмжлэгтэйгээр 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүүхдийн амбулатори, нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээ, сэргээн засах, “Төв” салбарын НҮЭМ-ийн цогцолбор, биеийн тамир, чийрэгжүүлэлт, хоолзүйн кабинет, “Хайлааст” салбарын шүдний кабинетуудад шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, цэвэрлэгээ, ариутгал угаалгын багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан. Мөн дүүргийн төсвийн 100,0 сая төгрөгийн хөрөнгөөр хүүхдийн амбулаторийг тоног төхөөрөмжөөр хангах, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгууллаа. Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Хайлааст”, “Чингэлтэй” ОНХХ-өөс УВЧ-2, ИСКРА-1, утлагийн 7 аппаратыг	

			<p>нэгдсэн эмнэлгийн сэргээн засах-уламжлалт эмчилгээний тасгийн цахилгаан эмчилгээ, хүүхдийн тасагт хүлээлгэн өгсөн. Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны явцад эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх талаар санал хүсэлтээ уламжлан ажилласнаар ЗГ, ЭМЯ-ны сайдаас АХБ ЭМСХХ-6 төслийн хүрээнд Чингэлтэй дүүрэгт Нэгдсэн эмнэлгийн стандартын барилгатай болох шийдвэрийг гаргуулсан. Дүүргийн 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭМТ-ийн төв салбарын 1-3 давхрын хүлээлгийн танхимийг тохижуулах, үйлчлүүлэгчдэд ээлтэй, тав тухтай орчин бүрдүүлэхээр ажиллаж байна. Ротари “Нарлаг” клубтэй хамтран Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн 80 орыг шинэчлэх, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх “Стандартын ор” төслийг санаачлан хэрэгжүүлж байна. Үүний дагуу эхний ээлжийн хүүхдийн 2-р тасгийн 15 орыг шинэчилж, шинэ гудас, хөнжил, цагаан хэрэглэлээр хангасан.</p> <p>НЭМГ, БНСУ-ын ROY корпорацийн хамтын ажиллагааны хүрээнд ӨЭМТ бүрт шээсний шинжилгээний анализатор 1 жилийн хэрэглээний нийт 32000 ширхэг тестийг хүлээлгэн өгч үйл ажиллагаандаа ашиглаад байна. Шинжилгээ авах, тоног төхөөрөмжийн ажиллах горимын сургалтыг 32 эмч, сувилагчид зохион байгуулсан.</p>	
	35	2. Дүүргийн эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэн, барилгын ажлыг эхлүүлнэ.	2016 оны 5-р сард БНТУ-ын Станбул хотын дарга НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай уулзан Улаанбаатар хотод 10 эмнэлгийн барилга барих тухай гэрээ байгуулсны дагуу эмнэлэг сонгох Туркийн комиссын гишүүдэд “Хайлааст” салбарын барилгыг үзүүлж саналаа дэвшүүлсэн.	90
	36	3. Дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт иргэдэд эмнэлгийн яаралтай түргэн тусламж үзүүлэх пунктыг барих ажлыг эхлүүлнэ.	Дүүргийн засаг даргын А/560 тоот захирамжаар 7-р хорооны нутаг дэвсгэрт яаралтай түргэн тусламжийн пунктыг барих сонгон шалгаруулалт хийгдэж гүйцэтгэгчээр Комптрейд ХХК шалгаран барилгын	90

				ажлыг 2016.04.15-наас 2016.11.10-нд хийж гүйцэтгэхээр болсон боловч Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар эрүүл ахуйн шаардлага хангахгүй гэж үзэн скез зургийг баталж өгөөгүй ба дэд бүтэцгүй газар эмнэлэг барихгүй гэсэн хариу өгсөн.	
17	1.2.4. Дүүрэгт Хүүхдийн Нэгдсэн эмнэлэг байгуулна.	37	1. Дүүргийн 15 дугаар хороонд Хүүхдийн нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр баригдах хүүхдийн нэгдсэн эмнэлгийн барилгыг гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд Асар өргөө ХХК-тай шууд гэрээ байгуулсан ба одоогоор ерөнхий ажлын зураглал хийгдсэн. Архитектур төлөвлөлтийн даалгавар гарсан. Онцгой байдлын газар барилгын хөгжлийн төвөөр зургийг хянуулахаар хүлээгдэж байна.	90
18	1.2.5. “Цахим засаглал”-ыг төгөлдөржүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгоно.	38	1. “Цахим эрүүл мэнд” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах замаар хүн амын мэдээлэл, бүртгэл судалгааны мэдээллийн санг баяжуулна.	Дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийг цахим хаягтай болгож, эрүүл мэндийн төвөөс өрхийн эрүүл мэндийн төврүү мэдээллийг цахим хэлбэрээр өгч хэвшсэн. ЭМСЯ-наас цахим засаглалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 64 ширхэг компьютер нийлүүлэн программ хангамж суулгах бэлтгэл ажил хийгдсэн. ЭМТ, ӨЭМТ-үүдийг онлайн хурал зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган програм хангамжуудыг суулгаж туршилт байдлаар 3 удаагийн хурлыг зохион байгуулсан. Бага тойруу, Хайлааст салбарууд, Хүүхдийн амбулаторийн нийт эмч, ажилтнуудад цахим бүртгэлийн үйлчилгээ, Health-Info3.0 програм хангамж ашиглах сургалтыг Эрүүл мэндийн мэдээллийн технологийн албанаас зохион байгуулсан. Эрүүл мэндийн төвийн хэмжээнд статистик мэдээлэл, цахим бүртгэл, дүрс оношлогоо, лаборатори, хавдар, халдварт, сүрьеэ, цус цусан бүтээгдэхүүн, өргөдөл гомдол, архив бичиг хэрэг, эмийн сан, санхүү, хүний нөөцийн чиглэлээр нийт 23 төрлийн мэргэжлийн програм хангамжуудыг ашиглаж хэвшсэн. Дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж буй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд тоног төхөөрөмж бүрэн суурьлагдаж, сайдын 2016 оны 1а/3366 албан даалгаврын хүрээнд эмнэлгийн	100

			төрөлжсөн програм хангамжийг хүлээн авах, нэвтрүүлэх ажил хийгдэж байна.		
		39	<p>2. Дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй сурталчлах вэб сайттай болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.</p>	<p>Эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ, үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор www.chemn.ub.gov.mn вэб сайт, www.facebook.com/Chingelteil.EMN/ фэйсбүүк хуудсыг ажиллуулж байна. Өдөр тутмын мэдээллийн шинэчлэлт тогтмол хийгдэж хэвшсэн. Цахим хуудасны нийт хандалт 2.495.174 байна. Фэйсбүүк хуудас 1.461 Like авсан байна. Мэндцолмон, Энэрэнгүй үйлс, Ижил санаа, Чинхүслэн, Мөнх-Үйлстэн зэрэг өрхийн эрүүл мэндийн төвүүд monnet.mn/mendtsolmon, enerengui-uils.ub.gov.mn, ijil-sanaa.ub.gov.mn, chin-huslen.ub.gov.mn, monnet.mn/mend.arvijih гэсэн хуудсуудыг ажиллуулж байна.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагуудыг цахим хуудасжуулах ажлын хүрээнд 8 өрхийн эрүүл мэндийн төв цахим хуудас, 10 өрхийн эрүүл мэндийн төв фэйсбүүк хуудсыг идэвхтэй ажиллуулж иргэдтэйгээ тогтмол ажиллаж байна.</p>	100
19	1.2.6. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээг сайжруулан, зориулалтын байртай болгох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	40	<p>1. Дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн иргэдэд үзүүлэх эмчилгээ, тусламжийн үйлчилгээг нэмэгдүүлж, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн хамтын ажиллагааг сайжруулах “Хороо, өрхийн эрүүл мэндийн төв хамтдаа” 6 сарын аян зохион байгуулна.</p>	<p>Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг чанартай, үр дүнтэй зохион байгуулах, эрчимжүүлэх хороо, ӨЭМТ-ийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын А/442 тоот захирамжаар “Иргэдийн төлөө Хороо, ӨЭМТ хамтдаа болзолт уралдаан зарласан. Тус уралдааны хүрээнд ӨЭМТ-үүд ДЗМОУБ-тай хамтран “Ариун цэврийн байгууламжаа сайжруулах” CLTS аргачлалыг 7-19-р хорооны ӨЭМТ-үүд хэрэгжүүллээ. ӨЭМТ-ийн дарга болон хороодын нийгмийн ажилтан нарт 1 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p>	100
		41	<p>2. Дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт жишиг Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг барьж ашиглалтанд оруулна.</p>	<p>Дүүргийн 12 дугаар хороонд Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын даргын 2015 оны 1-р сарын 27-ны өдрийн дугаар ДТ15/14 архитектур төлөвлөлтийн даалгавраар “Өрх, НЭМ-ийн жишиг төв”-ийн барилга угсралтын ажлыг Нью консртакшин ХХК гүйцэтгэж</p>	100

				ашиглалтад оруулахад бэлэн болоод байна.	
20	1.2.7. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх орчинг бүрдүүлэн, дугуйн болон алхах, гүйх зам, талбайг байгуулна.	42	1. Монголын бүх ард түмний XIV их наадмыг зохион байгуулах, дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын бэлтгэл, сургалтыг нэмэгдүүлэх замаар спортын уралдаан тэмцээнд оролцох нөхцлөөр ханган дэмжиж ажиллана.	Монголын бүх ард түмний XIV их наадмын хүрээнд иргэдийн спортын 5 дугаар их наадмын анхан шатны тэмцээнийг спортын 40 төрөлт тэмцээнд 4985 тамирчин оролцлоо. Бүх ард түмний шигшээ багийн 6 төрөлд дүүргийн тамирчид оролцож 3 алт, 2 мөнгө, 6 хүрэл медаль хүртсэн. Дүүргийн хэмжээнд өсвөрийн шигшээ багийн хүүхэд залуучуудын бэлтгэл сургуулилтыг нэмэгдүүлэх, спортын уралдаан тэмцээнд тогтмол оролцуулах зорилгоор спортын 13 төрлийн тэмцээнийг зохион байгуулж 2589 хүүхдийг хамруулсан. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг нь спортын 13 төрлөөр тогтмол хичээллэж хагас жилийн байдлаар нэрэмжит тэмцээн 31, УБ хотын АШТ тэмцээн 40, УАШ тэмцээн 26, ОУ-ын тэмцээн 27, Ази тивийн АШ тэмцээн 4 медаль тус тус хүртсэн ба нийтдээ 36 тэмцээнээс 128 медаль хүртсэн амжилтыг үзүүлээд байна. Өсвөрийн ширээний теннисний тамирчид Малайз улсад Олон улсын тэмцээнд оролцсон. Якутын хамтын ажиллагааны хүрээнд чөлөөт бөхийн 10 тамирчин хамтарсан бэлтгэл хийлээ.	100
		43	2. Дүүргийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15, залуучуудын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 10 төрлөөр тус тус зохион байгуулна.	Дүүргийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 13 төрлөөр зохион байгуулан давхардсан тоогоор 142 гаруй байгууллагын 2589 өсвөрийн тамирчид хамрагдсан. Залуучуудын спортын 10 тэмцээнийг зохион байгуулж 610 хүнийг хамрууллаа.	100
		44	3. Нийтийн биеийн тамир, спортыг сурталчлах, хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил явуулах, “Ажлын байранд дасгал хөдөлгөөн хийж хэвших” хөдөлгөөн өрнүүлэн ажиллана.	Дүүргийн нутаг дэвсгэр дахь төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчид, иргэдээс нийт 13485 хүнээс Бие бялдарын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авч Биеийн тамир, спорт хорооны сайтанд байршууллаа. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдарын хөгжлийг үнэлж дүгнэх, тэдний бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор жил бүр зохион байгуулагддаг 7-	100

				17 насны сурагчдын “Сорил тэмцээн 2016”-г зохион байгуулж, 13 сургуулийн 836 тамирчин гар дээр сунгалт, гэдэсний таталт, байрнаас уртад харайх, бөмбөгөөр бай онох, уян хатан, хавсралттай шилжилт, 50м-ийн гүйлт, 1000, 1500м-ийн гүйлт гэсэн 7 төрлөөр өрсөлдсөн. “Ажлын байранд дасгал хөдөлгөөн хийж хэвших” хөдөлгөөн өрнүүлэх зорилгоор 40 гаруй аж ахуйн нэгж байгууллагад ажлын байран дахь дасгал хөдөлгөөний CD, гарын авлагыг тараан, зөвлөгөө өгөөд байна.	
		45	4. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн ба төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчид болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 40-өөс доошгүй удаа уралдаан тэмцээн зохион байгуулна.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, аж ахуй нэгж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан албан хаагчдын дунд давхардсан тоогоор 65 удаагийн тэмцээнд спортын 40 төрөлд 4985 тамирчин оролцсон байна.	100
21	1.2.8. Дүүргийн усан бассейн бүхий Спорт цогцолбор, 23 дугаар сургуулийн дэргэдэх мөсөн гулгуурын байгууламжийг барьж ашиглалтад оруулна.	46	1. Дүүргийн спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлэн хийхэд Улс, Нийслэл, дүүрэг, иргэдийн санал, санаачлагыг дэмжин гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татан ажиллана.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10 дугаар хороонд баригдаж буй 1000 хүний суудалтай Спорт цогцолборын барилгын ажлыг “Люкс вүүд хаус” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 4 давхрын краказ цутгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	70
22	1.2.9. Дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэр Хайлаастын аманд Өвлийн спортын цогцолбор, цанын бааз байгуулна.	47	1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Өвлийн спортын цогцолбор, цанын бааз байгуулах ажлыг эхлүүлэхэд иргэд, аж ахуй нэгж байгууллага, олон улсын байгууллагын санал санаачлагыг өрнүүлж, Улс, Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтыг тусгуулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Дүүргийн Засаг даргын 2015 оны А/45 тоот захирамжийн дагуу тус дүүргийн 16-р хороо Согоотын аманд газар эзэмших эрхийг баталгаажуулан Өвлийн спортын цогцолбор цанын баазын зураг төсөл боловсруулах бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.	70
1.3. Нийгмийн халамж, хамгаалал					
23	1.3.1. Нийгмийн халамжаас	48	1. Дүүргийн ИТХ-ын 2014 оны 81	Хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийн өрхийн 46	100

<p>хамааралтай өрхийн тоог бууруулан гэр бүл төвтэй бодлого боловсруулан, “Халамжаас хамгаалалд, хамгааллаас хөдөлмөрт” хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p>	<p>дүгээр тогтоолоор батлагдсан “Халамжаас хамгаалалд, хамгааллаас хөдөлмөрт” хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>хүүхдийг цэцэрлэгт хамруулсан. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх “Гэртээ харих зам” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2016 оны А/72 дугаар захирамжаар “Ажлын хэсэг” байгуулагдсан. Хөтөлбөрийн хүрээнд орон гэргүй тэнэмэл иргэдийг тоолж бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулснаар 80 гаруй иргэнийг халуун усанд оруулж, Улаан Загалмай хороотой хамтран иж бүрэн хувцаслаж, халуун хоол цайгаар үйлчилж, эмнэлгийн анхан шатны үйлчилгээг үзүүлээ. Сар шинийн баярыг тохиолдуулан 13761 ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа. Нийгмийн халамж, дэмжлэг хүсч өргөдөл ирүүлсэн 193 хүнд тусламж дэмжлэг үзүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд ажил хайгчаар 6 иргэнийг бүртгэн, 2 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. Төв аймгийн Батсүмбэр дэх Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн 90 жилийн ойг тохиолдуулан ахмад настныг халамжлан асрах ажилд нь дэмжлэг үзүүлж “Ор хөнжлийн даавуу” 200 ширхэгийг хандивласан. Өрхийн үйлдвэрлэл, аж ахуй, бичил бизнес эрхлэх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 251 төсөл ирүүлснээс 148 иргэний төсөл дэмжигдэж 209,0 сая төгрөгийн дэмжлэг олгогдсоноор 207 иргэн байнгын ажлын байраар хангагдсан. “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т хамрагдсан өрхийн насанд хүрсэн гишүүдэд хөдөлмөрийн биржид нээлттэй байгаа ажлын байранд бүртгүүлэх, ажилд зуучлуулах үйлчилгээг үзүүлэх зорилготой сургалтыг 1-19 хороонд 2016.05.01-нээс 2016.05.10-ны хооронд бүсчилсэн байдлаар зохион байгуулж 210 иргэнийг хамруулж, 210 иргэнийг ажил идвэхтэй хайгчийн бүртгэлд бүртгэж, одоогийн байдлаар сургалтанд хамрагдсан иргэдийн 42 иргэн байнгын болон түр ажлын байртай болоод байна. Нэн ядуу өрхүүдийн</p>
---	---	--

				эдийн засгийг сайжруулахаар “Төгсөлтийн аргачлал” хөтөлбөрийн хүрээнд 7,12,16,17-р хороодын 75 өрхийн гишүүдийг мэргэшүүлэх сургалтанд хамруулж 25 өрхөд үйлдвэрлэлээ эрхлэх тоног төхөөрөмжийг олгосон.	
24	1.3.2. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээ, сонголтод түшиглэсэн халамжийн олон талт үйлчилгээг бий болгон, түүнд иргэн, иргэний нийгмийн байгууллагыг оролцуулах боломжийг бүрдүүлнэ.	49	1. Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачилгад тулгуурлан дүүргийн эмзэг бүлгийн иргэд, өрх толгойлсон эх /эцэг/-чүүдэд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ.	Зорилтот бүлгийн өрхийн эдийн засгийг сайжруулахаар 7, 12, 16, 17-р хороодод “Төгсөлтийн аргачлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэн 100 өрхийг сонгон авч өрхийн амьжиргаагаа сайжруулах сургалтанд хамруулан үйлдвэрлэл эрхлэх тоног төхөөрөмжийг 80 өрхөд олгосон. Мөн 15,17-р хорооны бичиг баримтгүй 17 иргэнд бичиг баримтыг олгосон. Ажил хайгч зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг ганцаарчилсан хэлбэрээр 174 , бүлгээр 1500, нийт 1674 иргэнд хүргэн ажиллалаа. Хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд 7-19 хорооны зорилтод бүлгийн 564 өрхийн том хүн-1696, хүүхэд-1691 нийт 3951 иргэн хамрагдаж хүнсний гол 10 нэр төрлийн бүтээгдэхүүнд нийт-33,052,500 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа олгоход зарцуулсан байна. Зорилтот бүлгийн болон нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай 230 хүнд тусламж, дэмжлэг үзүүлсэн. “Сүрьеэгийн эрсдэлтэй хүн амд идэвхтэй илрүүлэг” үзлэгийг 11,12,17,18-р хороодод зохион байгуулж 3578 иргэн хамрагдсан.	100
		50	2. Хүүхдийн эрхийг хамгаалах “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	Дүүргийн 19 хорооны Хамтарсан багийг идэвхжүүлэх зорилгоор “Хамтарсан багийн хамтын ажиллагаа” 3 сарын уралдаант аяныг зохион байгууллаа. Тус аяны хүрээнд хороод зорилтот бүлгийн эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийн судалгааг гаргаж хүүхэд хамгааллын эрсдлийн програмд 475 хүүхдийн мэдээллийг оруулсан. Нийт 71 кейс дээр ажиллаж хариу үйлчилгээ үзүүлсэн ба гэр бүлийн хүчирхийлэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд олон нийт хүүхэд рүү чиглэсэн 45 төрлийн сургалт, нөлөөллийн ажлыг 21253 хүнд зохион байгуулж,	100

			архины хамааралтай хүмүүстэй ажиллаж 2 хороон дээр “Эрүүл иэдвхитэй амьдрал клуб” байгуулсан байна. Аяныг дүгнэхэд 5,9,13 дугаар хороод эхний байрыг эзэлж шагнагдлаа. Өвөрхангай аймгийн Хархорин сумын хамтарсан багийн 20 гаруй ажилтан албан хаагчид 9, 10 дугаар хорооны “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааны танилцаж, харилцан туршлага солилцлоо. Салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор Кейс хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгууллаа. Хамтарсан багийн гишүүдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 4 төрөлт спортын тэмцээнийг хороодын хамтарсан багуудын дунд зохион байгууллаа.		
		51	3. Дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр иргэний цахим үнэмлэхээ үрэгдүүлсэн, бичиг баримтгүй, хөдөлмөрийн насны нийгмийн туслалцаа дэмжлэг хэрэгтэй байгаа иргэдийг бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн хэмжээнд нэн ядуу, бичиг баримтгүй иргэдийн судалгааг гаргаснаар “Дэлхийн зөн Хайлааст орон нутгийн хөгжлийн төвтэй хамтран 18 иргэнийг бичиг баримтжуулах ажлыг зохион байгууллаа.	100
25	1.3.3. Иргэдийг амьдралын зөв дадалд сургах, хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх үүсгэл санаачилгыг дэмжин, үүнд чиглэсэн үйлчилгээний газрын тоог нэмэгдүүлнэ.	52	1. Хүүхэд залуучуудыг амьдралын зөв дадалд сургах, хөгжүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үүсгэл санаачилгыг дэмжин ажиллана.	Иргэний Боловсролын Төв, Нээлттэй нийгэм форумтай хамтран 15–18 насны хүүхдүүдийн дунд хүчирхийллийн асуудлыг ялангуяа үе тэнгийхэн бие биеэ дээрэлхэх үзэгдлийг илрүүлэх, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх зорилгоор дотно яриа хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт 15-р хорооны 20 залуучуудын төлөөллийг хамруулан нээлттэй ярилцлага өрнүүлж, 2 кейс нээн ажиллалаа. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд “Зөв хүүхэд-Зөв сонголт 2016” дэвжээ тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 12 сургуулийн 96 сурагч, эцэг эх, багш нарын төлөөлөл бүхий багууд оролцож авхаалж самбаагаа сорьсноос 1-р байрт 117-р сургууль, 2-р байрт 50-р дунд сургууль, 3-р байрт 5-р дунд сургууль, тусгай байранд 39-р	100

			<p>сургууль тус тус шалгарлаа. Дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх Үе тэнгийн боловсролын үндэсний сүлжээний сургагч багш нар 49, 117 сургуулийн ахлах ангийн нийт 200 гаруй сурагчдад гэр бүл төлөвлөлт, үерхэл нөхөрлөл ба харилцаа, өсвөр үеийнхний НҮЭМ, БЗДХ, үр хөндөлт гэсэн сэдвүүдээр “ӨРТӨӨЧИЛСӨН СУРГАЛТ”-ыг зохион байгууллаа. Зорилтот бүлгийн хүүхдүүдийн авъяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, хамгааллын үйлчилгээг сайжруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж дүүргийн хэмжээнд 7 хүүхдийг “Хүслийн захидал” төсөлд хамруулсан. Төсөлд хамрагдсан хүүхдүүдийг өөрсдийн хүсэл сонирхолын дагуу боловсрол, урлаг, спортын сургалтанд хамруулсан. Одоо 5 хүүхэд англи хэлний сургалтанд суралцаж байна.</p>	
	53	<p>2. Дүүргийн иргэдийн залуу, дунд, ахмад үеийн гэр бүлийн уулзалт, хүүхдийн хүмүүжил, гэр бүлийн сайн туршлагыг иргэдэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж ажиллана.</p>	<p>“Гэр бүлийн үнэ цэнэ” сургалтыг 11-18 дугаар хорооны 250 гаруй залуу гэр бүлүүдийг хамруулан зохион байгуулж нээлттэй ярилцлага өрнүүлж, сайн туршлага солилцлоо. Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Хайлааст”, “Чингэлтэй ОНХХ-тэй хамтран “Хүүхдийн хөгжил төлөвшилд эцэг эхийн үүрэг, оролцоо” эцэг эхийн зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд сургууль цэцэрлэгийн эцэг эх, хүүхдийн төлөөлөл, хороо, сургуулийн нийгмийн ажилтнууд зэрэг 190 гаруй хүн оролцож хүүхдийн хүмүүжил, хөгжилд эцэг эхийн үүрэг оролцооны талаар хэлэлцлээ. “Хүүхдэд ээлтэй Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд “Бид гэр бүлдээ хайртай” өдөрлөгийг 19 хороодод нэгэн зэрэг зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр “Хүүхдэд ээлтэй Улаанбаатар” хөтөлбөр болоод түүний хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн агуулга, ач холбогдлыг иргэдэд танилцуулж, хороо тус бүр Авъяаслаг гэр бүл, Спортлог гэр бүл, Оюунлаг гэр бүл, Хүмүүнлэг гэр бүл, Бүтээлч гэр бүл зэрэг 5 номинациар шилдэг гэр бүл, шилдэг 2 хүүхэд буюу нийт дүүргийн хэмжээнд 95 гэр</p>	100

				бүл 38 хүүхдийг шалгаруулж урамшууллаа.	
26	1.3.4. Дүүрэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран хамгаалах, нөхөн сэргээх төв байгуулан, тусгай зориулалтын зам, шат, хаалга, бие засах газруудын тоог нэмэгдүүлснээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй дүүрэг болно.	54	1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, гарц, шат, хаалга, бие засах газрын стандартыг мөрдүүлэн ажиллана.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хувийн болон төрийн өмчийн 10 байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, гарц, шат, хаалга, бие засах газрын стандартыг мөрдүүлэн ажиллах талаар албан тоотыг хүргүүлж, Монголын тэргэнцэртэй иргэдийн холбоотой хамтран сургалт зохион байгуулж, 31 иргэн сургалтанд хамрагдлаа. Шинээр ашиглалтад орсон 224-р цэцэрлэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шат, ариун цэврийн өрөөг иж бүрнээр тохижуулсан. Мөн 102-р цэцэрлэгийн өргөтгөл, 8,16,18-р хороодод шинээр баригдах цэцэрлэг, 12,16,17-р хороодод шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн цогцолборуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шат, ариун цэврийн өрөөг стандартын дагуу хийхээр зураг төсөв гарган ажиллаж байна. Хүүхдийн номын өргөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шат, ариун цэврийн өрөөг стандартын дагуу мөрдөн ажиллаж байна.	100
		55	2. Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн "Асран хөгжүүлэх төв"-ийн газрын асуудлыг шийдвэрлүүлж, зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгэнэ.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд "Гэгээлэн", "Шинэ хос номин оюу", "Сайн хөрш" нийгэмлэг, Хүүхэд хамгааллын төвүүдтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Тус төвүүдээс 100 гаруй хүүхдүүд асаргаа сувилгаа, хөгжлийн үйлчилгээ авч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өдөр өнжүүлэх төв болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 20 гэр бүлд нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвөлгөө мэдээлэл өгч гарын авлага тараасан. Дүүрэг бүрт байгуулах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хөгжүүлэх төвийн байршлын саналыг Нийслэлийн халамж үйлчилгээний газарт хүргүүлсэн. 18 дугаар хорооны нутаг дэвсгэр дээр байрлах "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэмжих үйлчилгээний төв" НХГБХГ-т шилжсэнээр Нийслэлийн хэмжээний Хөгжлийн бэрхшээлтэй	90

				хүүхдийг хөгжүүлэх төв болон өргөжиж үйл ажиллагаа нь тогтмолжих нөхцөл бүрдсэн. Одоогоор 21 хүүхэд хамрагдаж байна.	
27	1.3.5. Дүүрэгт Ахмадын сувилал байгуулж, ашиглалтад оруулна.	56	1. Ногоон булан ахмадын амралт сувилал ОНӨААТҮГ, Цонжинболдог дахь ахмадын амралт ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааг жигдрүүлж, тогтмол ажиллагаатай болгоно.	Ногоон булан ахмадын амралт сувилалд Хороодын Ахмадын зөвлөлтэй хамтран 191 ахмад настанг амраасан ба Нийслэлийн Ахмадын хороотой хамтран “ӨНӨ ЭНХ” сувилалд 6 хорооны 12 ахмад настныг 5 хоног үнэгүй амрааж сувилуулсан. Дүүргийн хөрөнгө оруулалт 64 сая төгрөгөөр 45 м2 эрүүл ахуйн стандартад нийцсэн бэлтгэлийн ерөө бүхий гал тогооны барилгыг шинээр барьж, хуучин хоолны заалыг томсгон засварлаж 80 амрагч хооллох хоолын заалтай боллоо. Цонжинболдог дахь ахмадын амралт ОНӨААТҮГ-тай хамтран Засаг даргын Тамгын газрын цасны баярыг зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд 97 хүн оролцсон. Цонжинболдог дахь ахмадын амралт ОНӨААТҮГ-ын хашаа барих 40 сая, угаалгын газар, ажилчдын байр барихад 40 сая нийт 80 сая төгрөгийн үйл ажиллагааны тендэр зарлагдан хуулийн дагуу үйл ажиллагааг зохион байгууллаа.	100

ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ		2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЕЛЭЛТ	ХУВЬ
ХОЁР. НЭЭЛТТЭЙ ОРЧИН-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ				
2.1. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ				
28	2.1.1. Дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.	57	1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн биеэ даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулна.	100

			<p>POS-API програм ашиглаж байгаа 74, захиалга өгч хүлээгдэж байгаа 600, судалгаанд байгаа 473, цаашид үйл ажиллагаа явуулахгүй 137 татвар төлөгчийн бүртгэл хийлээ. Мэдэгдэл, ярилцлага 985 татвар төлөгчдөд хийсэн бөгөөд 17 байгууллагаас зөрчил илрүүлэн ажиллалаа. Мөн дүүргийн Засаг даргын 2016 оны А/40 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бүртгэлтэй бүх төрлийн тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажлыг 2016.02.01-нээс 2016.05.31-ны өдрийг хүртэл зохион байгуулан ажиллах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Татварын орлогын бааз суурийг нэмэгдүүлэх, татварын нэр төрлөөр тасарч буй орлогын шалтгаан нөхцлийг тодруулах, дутуу төлөлт, өр авлагыг барагдуулах чиглэлээр Тамгын газрын даргын А/234 тоот тушаалын дагуу төсвийн орлогын төлөвлөгөөг хангахад чиглэгдсэн ажлуудыг Татварын хэлтэстэй хамтран хэрэгжүүлж ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/747 дугаар захирамж гарч Улс, нийслэл, дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлтийг хангах, дутуу төлөлт, өр авлагыг барагдуулах, татварын албанд бүртгэгдсэн хаяг байршилдаа байхгүй, оршин суугаа хаяг нь тодорхойгүй, татвар төлөхөөс зайлсхийж оргон зайлсан татвар төлөгчийг эрэн сурвалжлах, шүүхийн шийдвэртэй татварын өрийг барагдуулах чиглэлээр дүүргийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтэс болон Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран олон талт ажил зохион байгуулж, биелэлт үр дүнг 14 хоног тутам Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажилласан.</p>	
	58	2. Төсвийн төлөвлөлт, хуваарилалт,	2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар	100

			гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, ил тод, нээлттэй байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.	улсын төсөвт 42,861.0 сая төгрөг төвлөрхөөс 46,660.9 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 108.8 хувийн, нийслэлийн төсөвт 62,454,8 сая төгрөг төвлөрхөөс 53,742,1 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 86,0 хувийн, дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, орон нутгийн төсөвт 22,595,3 сая төгрөг төвлөрхөөс 27,942,6 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 123,6 хувийн тус тус биелэлттэй ажилласан.	
29	2.1.2. Монгол Улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, хяналт тавих ажлыг тогтмолжуулан, төсвийн сахилга хариуцлага, үр ашиг, тайлагнал, ил тод нээлттэй байдлыг хангана.	59	1. Төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийн зардал бууруулах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулна.	Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Төсвийн зарлагыг хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай” 147 дугаар тогтоол, 2015 оны “Төсвийн зардлыг бууруулах тухай” 230 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажлын байранд ашиглалтын хугацааны баталгаат засвартай, эрчим хүчний хэмнэлттэй “LED” гэрэлтүүлгийг тавьж ашиглалтанд оруулсан. Мөн төсвийн зардлын зарцуулалтын эрхийн хүсэлт баталгаагаар төсөвт байгууллагын санхүүжилтийн эрх болон холбогдох зардлуудыг өдөр тутам үндсэн баримтаар хянан, гүйцэтгэлээр нь олгох ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 2016 оны батлагдсан төсөвт тусгагдсан гэрэл цахилгаан, халаалт дулаан, цэвэр бохир усны үнэ, тариф тооцооллын үндэслэлийг үндсэн нэгжид удирдамж графикийн дагуу шалган зааварчлах ажлыг Дотоод аудитын албатай хамтран хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Түлш, нүүрсээр халдаг хороодын цогцолбор байруудад шаталтын хувь өндөртэй нано технологийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилго тавин судалгааны материалыг нэгтгэж, дүгнэлт хийн ажилласан.	100
		60	2. Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төсвийн захирагч, санхүү, бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах чиглэлээр сургалт	Дүүргийн төсөвтэй харилцагч төсвийн байгууллага болон дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогч, санхүү бүртгэлийн ажилтан нарт хийгдэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө, зарцуулах зардлын төсвийг батлуулж, үйл	100

		<p>семинар зохион байгуулж, мэдээллээр ханган ажиллана.</p>	<p>ажиллагааг хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний дагуу 4 удаагийн сургалтыг дүүргийн санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нийт 159 албан хаагчийг хамруулан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.</p>	
	<p>61</p>	<p>3. Дүүргийн төсвийн байгууллагуудын төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын ажил болон хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, үнэлэлт дүгнэлт өгнө.</p>	<p>Дүүргийн төсөвтэй харилцагч 66 төсөвт байгууллагуудаас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээг хянан хүлээн авч нэгтгэснээр дүүргийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын болон орон нутгийн төсвийн орлогын мэдээ, төсвийн зарлагын нэгдсэн мэдээ, төрийн сангийн орлого, зарлагын мэдээ, төрийн сангийн орлого, зарлагын нэгдсэн тэнцлийг хуулийн хугацаанд нь нэгтгэн гаргаж, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажилласан. Төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээний тодруулгыг нэгтгэн төсвийн зардлын гүйцэтгэлийн нөлөөллийг тооцон шилэн дансны мэдээлэлд оруулан тухайн сард үүссэн өрийн талаар үндсэн байгууллагаас нь тодруулан зохих арга хэмжээг авч ажилласан. Батлагдсан төсвийн хэрэгжилт зохих заавар, журмын дагуу явагдаж, урсгал засварын зардлыг зориулалтын дагуу зарцуулж, тайлан, тооцоог цаг хугацаанд гаргаж, улс ,нийслэл, дүүрэг, ОНХС-ийн хөрөнгө, тусламж, хандиваар бэлтгэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусган төсвийн шууд захирагч болон НӨХГ-ын зөвшөөрөл, шийдвэрээр нийт хамрагдсан 22 байгууллагаас 16 байгууллага буюу 72.7% нь хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусган, үлдэх 6 байгууллага буюу 27.3 % нь хүлээлцэх акт, шийдвэр баримтыг хүлээж байна. Байгууллагуудын агуулахын эмх цэгц, хөдөлгөөнт ярлик, эд хариуцагчийн АШБүртгэл, тооцоо, тайлан гаргалтын байдлыг хамруулан үзэхэд 22 байгууллагаас 10 байгууллага буюу 45.4% нь ямар нэгэн байдлаар</p>	<p>100</p>

				хангалтгүй, үлдсэн 12 байгууллага буюу 54.6% нь эрх үүргийн дүрмийн дагуу ажилласан. Шинэчлэн найруулагдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу дүүргийн төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулахад анхаарч ажилласан. Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу дүүргийн төсөвтэй харьцдаг 24 хувийн цэцэрлэг, 8 хувийн сургуулиудад хяналтын тооллого хийсэн.	
		62	4. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага болон төсвийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж аж ахуйн нэгж байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллана.	Дүүргийн төсөвтэй харилцагч 66 төсөвт байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр холбогдох мэдээллүүдийг Сангийн Яамны нэгдсэн мэдээллийн сан, өөрийн байгууллагын вэб сайт, мэдээллийн самбартаа сар бүр оруулан ажилласан ба сайтад мэдээллээ цаг хугацаанд нь шивж оруулахад анхаарах асуудал сэдвээр төсөвт байгууллагын нягтлан бодогчдод сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Дүүргийн орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн мэдээг Нийслэл, дүүргийн шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулан нийтэд мэдээлэн ажиллалаа.	100
30	2.1.3. Дүүргийн өмч хөрөнгийн менежментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ.	63	1. Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг хагас, бүтэн жилээр явуулан, Нийслэлийн өмчийн харилцааны газар болон Үл хөдлөх хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд бүрэн хамруулна.	Дүүргийн Засаг даргын 2016.04.20-ны өдрийн А/319 захирамжаар байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 118-н байгууллагын тооллогын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан заавар зөвлөгөөг өгч, байгууллагуудын тооллогын материалыг хүлээн авч, тооллогын комисс гарын үсэг зурж баталгаажуулан нэгтгэлийн програмд нэгтгэсэн. Тайлант хугацаанд дүүргийн өмч хүлээн авах байнгын комисс нийт 4073,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 92 ажлыг байнгын ашиглалтанд хүлээн авч ажилласан.	100

		64	2. Орон нутгийн өмчийн байгууллагуудтай өмч эзэмшүүлэх гэрээг хийж, байгууллагын өмч хамгааллын байнгын комиссын ажлыг эрчимжүүлнэ.	“Хөрөнгө бүртгэх тухай” Засаг даргын Тамгын газрын даргын Хөрөнгө бүртгэх тухай А/47 дугаар тушаалаар 2015 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн өмчийг данс бүртгэлд бүртгэж ажилласан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016.02.24-ны өдрийн хурлаар дүүргийн 2015 оны өмч ашиглалт, хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын танилцуулгыг хийсэн. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас дүүргийн төсөвт байгууллагуудтай байгуулсан өмч эзэмшлийн гэрээ дүгнэх шалгалтанд Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Эрүүл мэндийн нэгдэл, Боловсролын хэлтэс, Бизнес инкубатор төв, Онцгой байдлын хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн төв, 23-н цэцэрлэг, 13-н сургуулийг тус тус хамруулсан.	100
31	2.1.4. Нийслэл, дүүрэг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэн, хот тохижилт, бүтээн байгуулалтад чиглүүлж, “Орон нутгийн хөгжлийн сан” байгуулж, иргэд олон нийтийн оролцоотойгоор төлөвлөн зарцуулна.	65	1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг иргэд, олон нийтийн оролцоотойгоор төлөвлөн, зарцуулах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хийж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар иргэдээс санал авах ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулан ажиллалаа. Санал авах ажлын хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн санал авах хуудсыг 2 загвараар нийт 35000 ширхэг хэвлүүлэн дүүргийн 19 хороонд өрхийн тоонд нь харьцуулан хуваарилсан. Хуваарилагдсан саналын хуудсыг 35000 өрхөд тарааснаас 32799 ширхэг саналын хуудас бөглөгдөн ирж, саналын хуудасны буцаан авалт 93.7%-тай гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс 3.9 хувиар өссөн дүнг харуулж байна. Иргэдээс 32799 ширхэг саналын хуудсаар ирүүлсэн 90040 саналыг салбар, чиглэлээр нь ангилж үзэхэд 16.5 хувь нь нийгмийн чиглэлээр, 23.0 хувь нь дэд бүтэц, нийтийн үйлчилгээний чиглэлээр, 57.7 хувь нь тохижилтын чиглэлээр, 2.8 хувь нь бусад чиглэлээр тус тус санал ирүүлсэн байна.	100
		66	2. Улс, нийслэл, дүүргийн төсвөөс санхүүжигдэх төсөл арга хэмжээний уялдааг ханган, санхүүжилтийг	Дүүргийн болон ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хийж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг иргэд, олон нийтээс нээлттэй саналын хуудсаар авч,	100

			олгож, гүйцэтгэлд тавих хяналтыг иргэд, олон нийтийн оролцоотой зохион байгуулна.	дүүргийн хөгжлийн бодлого, нийгэм эдийн засгийн зорилттой уялдуулан боловсруулж ажиллалаа. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 56 төсөл, арга хэмжээнээс 53 ажлын гэрээг байгуулан холбогдох бичиг баримт, ажлын хуваарь, тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг үндэслэн 2929,7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон ба 50 ажил бүрэн хийгдэж дууссан.	
32	2.1.5. Худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлж, өрсөлдөөний шудрага нөхцөлийг бүрдүүлнэ.	67	1. Худалдан авах ажиллагаанд үр ашигтай, өрсөлдөөний шударга нөхцөл бүрдүүлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг мөрдөн ажиллана.	Дүүргийн төсвийн хөрөнгө, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яамны www.e-procurement.mn , дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хуудсуудад байршуулж, өдөр тутмын “Монголын үнэн” сонинд нийтлүүлж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажилласан. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-д заасны дагуу худалдан авах ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг www.shilendans.gov.mn сайтад байршуулсан. Тендерийн үнэлгээ хийх бүрт үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилтэй эсэх талаарх мэдэгдэлийг аван, Авлигатай тэмцэх газрын www.iaac.mn сайтад байршуулж байна. Тайлант хугацаанд давхардсан тоогоор үнэлгээний хорооны 126 гишүүнээс авсан мэдүүлгийг шивэн оруулаад байна.	100

		68	2. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган, иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэн, нээлттэй, тендерийн цахим худалдан авалтыг зохион байгуулна.	Засгийн газрын Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан “Цахим худалдан авах ажиллагааны 2-р үе шат системийн сургалт”-д дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны хоёр мэргэжилтэн хамрагдсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Худалдан авах ажиллагааны алба хамтран худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ гэрчилгээний олгох сургалтыг зохион байгуулж 8 төрийн албан хаагч, 2 төрийн бус байгууллагын төлөөлөл гэрчилгээ авсан. Тендерийн урилгыг цаг тухай бүр Сангийн яамны www.e-procurement.mn , дүүргийн www.chingeltei.gov.mn сайтуудад байршуулж, өдөр тутмын “Монголын үнэн” сонинд нийтлүүлж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Цахим худалдан авалтыг зохион байгуулах ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хорооны Тахилтын 2 дугаар гудамжинд хийгдэх гэрэлтүүлгийн ажлыг Засгийн газрын цахим худалдан авах ажиллагааны мэдээллийн систем буюу www.meps.gov.mn программаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.	100
33	2.1.6. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үнэн зөв байдлыг ханган, статистикийн мэдээ, судалгааны ажил болон хамрах хүрээг өргөжүүлнэ.	69	1. Дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээр “Статистикийн эмхэтгэл”, “Нийгэм, эдийн засгийн танилцуулга”-ыг сар, улирал, жилээр гарган иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр ханган ажиллана.	Дүүргийн эдийн засаг, нийгмийн байдлын танилцуулгын мэдээллийг цуглуулж нэгтгэн сар бүрийн 15-нд гаргаж дүүргийн хэлтэс албадын удирдлага, мэргэжилтэн мөн иргэд аж ахуйн нэгж байгууллагад хэвлэмэл байдлаар хүргэлээ. Мөн Нийслэлийн статистикийн газрын вэб хуудсанд байршуулж файл хэлбэрээр хэрэглэгчдэд түгээж байна. 2015 оны “Статистик эмхэтгэл”-ийн тоон үзүүлэлтүүдийг цуглуулж нэгтгэх шатанд явагдаж байна.	100
		70	2. Дүүргийн хүн ам, орон сууцны завсрын тооллогын дүнг нэгтгэн мэдээллэх болон оршин суугчдын аюулгүй байдал, орон сууцны хангамж, нөхцөл байдал, хүн амын хөдөлмөр эрхлэлт, мал тэжээвэр амьтны судалгааг хийнэ.	Дүүргийн хүн ам, орон сууцны завсрын тооллогын нэгдсэн дүнг эцэслэн гаргасан. Орон сууцны хангамж, нөхцөл байдлын судалгаа, Мал тэжээвэр амьтан, хүн амын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, дүүргийн оршин суугчдын аюулгүй байдал судалгааны үзүүлэлтийг цуглуулан, нэгтгэх шатанд явагдаж байна. Дүүргийн Засаг даргын 2016.04.12-ны өдрийн А/287 тоот	100

				захирамжийн дагуу Аж ахуй нэгж байгууллагын улсын тооллогыг явуулж нийт 12669 аж ахуй нэгж байгууллага хамрагдсан байна.	
34	2.1.7. Хүн амд нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	71	1. Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчдын хамрагдалтыг нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлнэ.	Нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж байгууллагыг нийгмийн даатгалд хамруулах олон талт ажлуудыг зохион байгуулснаар ажил олгогч 3720, заавал даатгуулагч 78286 болж, тайлант хугацаанд шинээр 463 ажил олгогч, 1873 даатгуулагчийг бүртгэн, 989.9 сая төгрөгөөр цалингийн сан нэмэгдлээ. Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын санд 128 тэрбум 234.7 сая төгрөгний шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 126 тэрбум 451.8 сая төгрөгийн орлого хуримтлуулж, хуримтлагдсан авлагаас 1 тэрбум 782.8 сая төгрөгийн авлага барагдуулж төлөвлөгөөт зорилтоо 100,0 хувиар биелүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн орлого 1.7 хувиар өслөө.	100
		72	2. Даатгуулагчдад үзүүлэх нийгмийн даатгалын цахим үйлчилгээг боловсронгуй болгон, цахим үйлчилгээг эрчимжүүлнэ.	www.ndaatgal.mn сайтад 7894 даатгуулагчийг бүртгэснээр даатгуулагч өөрийн төлсөн шимтгэлийг цахим хаягаараа хүлээн авах боломжтой боллоо. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цахимаар илгээсэн илгээлт 98.2 хувьтай байна. Нэрийн дансны мэдээллэх хуудсыг 134 сайн дурын даатгуулагч, 94 ажил олгогчийн 670 гаруй албан журмын даатгуулагчдын хүсэлтийн дагуу өгөгдсөн цахим хаяг руу илгээсэн. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа, ажил олгогчийн мэдээлэл, нэрийн дансны мэдээлэл, халамжийн мэдээллийг гаргах Лавлагааны ТҮЦ машинаас 6664 даатгуулагч лавлагаа авсан байна.	100
		73	3. Үндсэн ажлаас гадуур аж ахуйн нэгж, байгууллагад давхар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлөх дээд хэмжээнээс илүү төлсөн даатгуулагчийн шимтгэлийг буцаан олгох ажлыг	Үндсэн ажлаас гадуур хоёр ба түүнээс дээш аж ахуйн нэгж, байгууллагад давхар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлөх орлогын дээд хэмжээнээс илүү төлсөн 75 даатгуулагчийн 2011-2015 оны шимтгэлийн буцаан олголтыг шалгаж, 85.4 сая төгрөгийг олгоод байна.	100

			үргэлжлүүлэн зохион байгуулна.		
		74	4. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулахад мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Тайлант хугацаанд 9 удаагийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, 650 гаруй иргэдэд нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжоор мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа. Иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжоор тогтмол мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласнаар нийт 13351 иргэн сайн дурын даатгалд хамрагдсан. Ажил хөдөлмөр эрхлээгүй 11354 иргэн, 2176 суралцагч эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна Дээрх ажлуудын үр дүнд сайн дурын даатгуулагчдын хамрагдалт нэмэгдэж, сайн дурын даатгалд 2600.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2937.2 сая төгрөг төвлөрүүлэн 112,9 хувиар биелүүллээ.	100
		75	5. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежийн оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.	Их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран ажиллах "Санамж бичиг" байгуулснаар захирал, эрхлэгч, ня-бо нарт нийгмийн даатгалын салбарын хууль эрх зүйн шинэчлэл, эрүүл мэндийн даатгалын тухай хууль, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүдийн талаар сургалт зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэр дэх 15 сургуулийн 6100 оюутныг ЭМД-д даатгуулах гэрээ байгуулах ажил хийгдлээ.	100
2.2 Татварын бааз суурийг бэхжүүлэх					
35	2.2.1. Монгол Улсын Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган, татварын өр барагдуулалтыг стандартад хүргэж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	76	1. Далд эдийн засгийг ил болгох, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулснаар татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Татварын ерөнхий газар болон дүүрэг хороодын иргэний танхим, худалдааны төвүүдэд 22 удаагийн сургалтыг явуулж нийт 1435 татвар төлөгч хамрагдлаа. Татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх өрөөгөөр нийт 1458 татвар төлөгч үйлчлүүлсэн. Дүүргийн татварын хэлтсийн хяналт шалгалтын тасаг нь татвар төлөгчийн хүсэлтээр болон тусгай удирдамжийн дагуу нийт 250 татвар төлөгчийг шалган 61,0 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж 2,8 тэрбум	100

			<p>төгрөгийн нөхөн татвар, 4,3 тэрбум төгрөгийн торгууль, 197,6 сая төгрөгийн алданги нийт 3,2 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулснаас 59,6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 7 татвар төлөгчтэй холбоотой 2,4 тэрбум төгрөгийн төлбөрийн дүнтэй маргаантай акт гарсан байна.</p>	
	77	<p>2. Эрэн сурвалжиж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг илрүүлэх, татварт хамруулах, татан буулгах ажлыг эрчимжүүлэн, төрийн байгууллагуудтай мэдээ мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоог сайжруулна.</p>	<p>2016 оны эхнээс хаяг байршилдаа байдаггүй, тайлан балансаа өгдөггүй, 2137 ААН-ийг эрэн сурвалжилж татварт хамруулах, татан буулгах ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Улсын бүртгэлээс хасалт хийх тухай ГТЕГ-ын 2016 оны 03-1/2162 тоот албан бичиг, Улсын бүртгэл статистикийн ерөнхий газраас ирүүлсэн 576 хуулийн этгээдийн хасалтын карт болон өрийн тооцоолол, татвар төлөгчийн картыг бөглөн баталгаажуулж бүртгэлийн баазаас хасалтыг хийсэн болно. 2016 онд 78,496,223 төгрөгийн өртэй 8 аж ахуй нэгжийг шүүхэд нэхэмжилж эрэн сурвалжлах шүүхийн шийдвэр гаргуулан ажиллаж байна. Тусгаарлагдсан баазад бүртгэлтэй тайлан өгдөггүй, хаяг байршилдаа байдаггүй 13 ААН-тай ярилцлага хийж, дүүргийн Төрийн сангийн хэлтэс, татварын тайлан илгээх талаар болон татварын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгч байна. Татан буугдах ААН-ийн хүсэлтийг хяналт шалгалтанд хамруулахаар өгч байна.</p>	100
	78	<p>3. “Нийслэл хотын албан татварын тухай” хууль, “Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд урамшууллын систем нэвтрүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>Нийслэл хотын албан татварын тухай хуулийг дагаж мөрдөж эхэлсэнтэй холбоотой НТГазрын даргын болон Чингэлтэй дүүргийн хэлтсийн даргын удирдамжийн дагуу ажлын хэсэг гарган ажилласан. Тайлант хугацаанд 489 ААН, Иргэн Нийслэл хотын албан татвар төлөгчөөр бүртгэлтэй байна. 2016 оны 01 сарын 01-нээс эхлэн НӨАТ-ын тухай хууль болон урамшууллын систем нэвтрүүлж эхэлсэн. Үүнтэй холбоотой 2016 оны 1 сараас эхлэн ГТЕГ, НТГ, ЧДТХэлтсийн даргын удирдамжийн дагуу дүүргийн нутаг нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Иргэн,</p>	100

				ААН бүрээр очин мэдэгдэл, шаардлага хүргүүлэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж буй эсэхийг хянан бүртгэл явуулж зөвлөгөө өгч хууль тогтоомжийн хэрэгжилтэнд анхааран ажиллаж байна.	
36	2.2.2. Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгон, сургалт сурталчилгааны ажлын үр нөлөөг сайжруулна.	79	1. Татвар төлөгчдийн үйл ажиллагааны онцлог тохирсон үйлчилгээг нэвтрүүлэн, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулна.	Цахим татварын алба болох зорилтын хүрээнд нийт 47380 татварын тайлан хүлээн авч, 1600 татвар төлөгчийн цахимаар ирүүлсэн хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн ажилласан. Мөн энэ онд Хувь хүний тайланг цахим тайлангийн системээр авч, тайланг 98 хувь баталгаажуулан хүлээн авсан. Татвар төлөгчийн нэгдсэн "ТРИПС" системийг ашиглалтанд оруулж 2282 иргэнийг бусад аймаг, дүүрэгт харъяаллын дагуу, шилжүүллээ. Нэмэгдсэн өртгийн албан татварын улсын системд холбогдож үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээд бүр кассын машинтай болж цахим төлбөрийн баримт хэвлэж сугалаанд оролцдог цахим системд шилжсэн, Tax-act системээс хуулийн этгээд, иргэний мэдээллийг хөрвүүлж нэг мэдээллийн баазтай төвлөрсөн тогтолцоо бүхий TRIPS online горимын системд шилжсэн.	100
		80	2. Татварын хууль тогтоомжийг бүх талаар сурталчилж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг татварт бүрэн хамруулахад анхааран ажиллана.	Нийслэл хотын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн тухай харьяа дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж болон томоохон худалдааны төвүүдэд очин зөвлөгөө өгөх, тараах материал өгч мэдэгдэл, шаардлага хүргүүлэн, ярилцлагын тэмдэглэл хийж, сургалт зохион байгуулан заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Хувь хүний орлогын албан татвар, бууны албан татвар гэх мэт өөрчлөлт орсон хуулиудыг татвар төлөгчдөд таниулан заавар зөвлөгөө өгч байна.	100
2.3 Хөдөлмөр эрхлэлт					
37	2.3.1. Иргэдийн хөдөлмөрлөх эрхийг ханган “Бүтээмжтэй ажлын байр”, “Хамтдаа	81	1. Дүүргийн ИТХ-ын 2014 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Бүтээмжтэй ажлын байр”	Баялаг бүтээгчдийн “Дэд хороо”-г 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа. Баялаг бүтээгчдийн анхдугаар уулзалт, зөвлөгөөнийг 2016.02.29-нд зохион	100

	<p>хөгжье” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.</p>	<p>хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>байгуулсан ба зөвлөгөөнд 320 гаруй баялаг бүтээгчид оролцож, үзэсгэлэн худалдаанд 46 үйлдвэрлэгч оролцож бараа бүтээгдэхүүнээ борлууллаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйд тулгуурласан хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ахисан түвшин” сургалтыг зохион байгуулж, 36 албан хаагч хамрагдлаа. Мөн Жижиг дунд үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний чанар, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх талаар сургалт зохион байгуулсан. Сургалтанд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 23 хүн, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 12 хүнийг хамруулсан.</p>	
	82	<p>2. Дүүргийн ИТХ-ын 2014 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>Дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн “Төсөл дэмжих салбар хороо”-ны гишүүдийн ээлжит хурлыг зохион байгуулж, Залуучуудын хөгжлийн төвийн 2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа. 11-18 дугаар хороодын залуу эмэгтэйчүүд болон өрх толгойлсон эхчүүдэд “Миний эгчийн аврагч” киногоор хэлэлцүүлгийг зохион байгуулж, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, адил үүрэг гэж юу вэ, ямар тохиолдолд эрх тэгш байдал алдагдаж байна вэ, эцэг эхчүүдийн харилцаа хандлага гэх мэт асуудлуудаар ярилцлаа. Зөвлөлийн гишүүдийн уулзалтыг 2 удаа зохион байгууллаа. Амьдрах ухааны 8 цагийн сургалт хийж давхардсан тоогоор 280, хэлэлцүүлэгт 215 залуучууд, Шатрын клубын хүүхдүүдийг идэвхжүүлэх тэмцээн уралдаанд 40 хүүхэд хамрагдаж нийт 800 залууст үйлчилгээ үзүүлсэн. Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх шатар, даамны клубын гишүүдийн дунд АХА танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээн, “Цодгор хүү” шатрын тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнүүдэд ЕБС-ийн ахлах ангийн 60 гаруй сурагчид оюун ухаан, мэдлэг чадвараа уралдуулан өрсөлдлөө. Урлаг соёлоор</p>	100

			дамжуулан хүүхэд залуучуудын хүмүүжилд нөлөөлөх, хүйсийн тэгш харилцаа, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор Кино хэлэлцүүлэг 9 удаа зохион байгуулж 280 өсвөр үе залуучууд оролцсон. Залуучуудын дунд спортын 10 төрлийн тэмцээн зохион байгуулж 1000 орчим залуучууд оролцсон байна. Сургалт, хэлэлцүүлэг, урлаг, соёлын 10 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж нийт 2000 гаруй залуучууд хамрагдлаа.	
		83	3. Дүүргийн ИТХ-ын 2014 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэгчдийг чадавхижуулна.	100
38	2.3.2. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд банкны урт хугацааны, барьцаа шаардахгүй зээл олгоход бүх талын дэмжлэг үзүүлэн,	84	1. Дүүргийн ИТХ-ын 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллана.	100
			“Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын 4 зорилтын хүрээнд 12 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Жижиг, дунд өрхийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Хамтдаа хөгжье 2015” сэтгүүлийн анхны	

<p>“Зээлийн батлан даалтын сан”-тай хамтран ажиллана.</p>		<p>хувилбарт 151 жижиг, дунд өрхийн үйлдвэрлэгчдийн мэдээлэл, каталогийг www.chingeltei.gov.mn сайтын сэтгүүл хэсгээр, мөн PDF файлыг цахим ном хэлбэрээр http://setguul2015.chd-incubator.mn сайтад байршуулсан ба сэтгүүлийн 3 дахь хэвлэлд 152 үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүний танилцуулгыг оруулж, 2000 хувь хэвлүүллээ. Мөн PDF файлаар цахим ном хэлбэрээр оруулсан бөгөөд http://setguul2015.chd-incubator.mn линкээр орж унших боломжтой болгосон. Бизнес хөгжил сургалтыг “Facebook Маркетинг” сэдвээр зохион байгуулж нийт 12 үйлдвэрлэгчдийг хамруулсан. Сургалтаар үйлдвэрлэгч тус бүр цахим хуудастай болж Чингэлтэйд үйлдвэрлэв facebook group-ын гишүүд 157 болж өргөжсөн. Мөн сурталчилгаа, идэвхжүүлэлт хийх зорилгоор үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний каталогийг сайтад байршуулах, хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлд харилцан туршлага солилцох, бизнес хөгжлийн хүрээнд хялбаршуулсан аппликейшн татах, зурган файл засах, цахим маркетингийн зөвлөгөөг өгч эргэх холбоо тогтоох зэрэг үйлчилгээнүүдийн талаар мэргэжил арга зүйн удирдлагаар ханган цахим шуудан facebook хаягаар харилцах тухай мэдлэг олгосон. “Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн 3 дугаар зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа”-г 2016.04 сард зохион байгуулж, 450 гаруй үйлдвэрлэгчид оролцлоо. Зөвлөгөөнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 онд батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилт болон Оёдолчдын 1, 2 дугаар зөвлөгөөний үр дүнгийн талаар танилцуулга мэдээлэл хийсэн. Зөвлөгөөний үеэр жижиг дунд өрхийн үйлдвэрлэгч 30 гаруй аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүний үзэсгэлэн, худалдааг зохион байгуулж 250.0 мянган төгрөгийн борлуулалт хийгдсэн. Өрхийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сайжруулах тогтвортой ажлын байраар хангах зорилгоор 27 өрхийн</p>
---	--	--

			<p>үйлдвэрлэгчийг сонгон шалгаруулж, ажлын байраар хангаж байршуулснаар 60 гаруй ажлын байрны орон тоо нэмэгдэж өрхийн үйлдвэрлэлээс жижиг үйлдвэрлэлрүү шилжих боломжийг бий болгоод байна. Дүүргийн оёдлын кластерын төвийн үйл ажиллагааг идэвхижүүлж 14,17 дугаар хороодын 6 иргэнийг тогтмол ажлын байраар ханган ажиллуулж байна. Тус төв нь 3 дугаар улирлын байдлаар “МТОТ” ХХК-ийн 150 ширхэг сурагч цэнхэр цамцыг 375 мянган төгрөгөөр, “ТТJV” ХХК-иас 6,0 сая төгрөгний харуул хамгаалалтын хувцас, мөн харуул хамгаалалтын “Хараат” ХХК-ийн 1,8 сая төгрөгний ажлын хувцасыг тус тус үйлдвэрлэсэн.</p>	
	85	<p>2. Барьцаа хөрөнгийн дутагдалтай аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд хамруулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Чингэлтэй дүүргийн “Баялаг бүтээгчдийн анхдугаар уулзалт зөвлөгөөн” болон “Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн 3 дугаар зөвлөгөөнийг зохион байгуулж нийт 770 гаруй жижиг, дунд өрхийн үйлдвэрлэгчид хамрагдсан. Зөвлөгөөний үеэр зээлийн батлан даалтын сангаас дүүргийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн хүрээнд өрхийн болон үйлдвэрлэгч нарыг зээлийн батлан даалтын үйлчилгээнд хэрхэн хамрагдах талаар мэдээлэл өгч, гарын авлага материалаар ханган ажилласан. Тайлант хугацаанд зээлийн батлан даалтын санд 4 иргэн, 3 ААН хамрагдаж 2,7 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 5,0 тэрбум төгрөгийн зээлийг үйлдвэрлэл эрхлэгч нарт олгож ажилласнаар шинээр 65 ажлын байр, 30 ажлын байр хадгалагдан нийт 95 ажлын байртай болсон.</p>	100
	86	<p>3. “Зээлийн батлан даалтын сан”, хороодод үйл ажиллагаа явуулж буй хадгаламж зээлийн хоршоодтой хамтран жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдийн дунд мэдээллээр хангах сургалт зохион</p>	<p>Хадгаламж зээлийн хоршоогоор дамжуулан санхүүжилт авсан 25 жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэгч нарт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл, Азийн хөгжлийн банкны “Батлан даалттай” зээлийн мэдээлэл өгч гарын авлага материалаар ханган ажиллалаа. Жижиг, дунд, өрхийн үйлдвэр эрхлэгчдэд батлан даалтын үйл ажиллагаа,</p>	100

			байгуулна.	батлан даалт гаргах журмын талаар суралт зохион байгуулж, нийт 20 гаруй иргэн, аж ахуй нэгжийг хамруулан илтгэл тавьж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хадгаламж зээлийн хоршоогоор дамжуулан санхүүжилт авсан 14,15,17 хорооны 25 жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэгчдэд үйл ажиллагаа өргөжүүлэхэд нь дэмжлэг болох зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл, Азийн хөгжлийн банкны “Батлан даалттай” зээлийн мэдээллэл өгч гарын авлага, материалаар ханган ажилласан. Дүүргийн хэмнээд нийт 18 хороонд хадгаламж зээлийн хоршоо байгуулагдаж 700 гаруй иргэн хамрагдаж хувь нийлүүлээд байна.	
39	2.3.3. Хөдөлмөр зуучлалын “Чингэлтэйн онлайн” сүлжээг нэвтрүүлж, 5000-аас доошгүй ажилгүй иргэдийг ажилд зуучлан байнгын ажлын байртай болгоно.	87	1.Хороодод байршуулсан хөдөлмөр зуучлалын “Чингэлтэйн онлайн” сүлжээ И-Бирж, Hudulmur.mn сайтаар дамжуулан иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэнэ.	Хороодод байршуулсан хөдөлмөр зуучлалын “Чингэлтэйн онлайн” сүлжээ И-Бирж, Hudulmur.mn сайтаар дамжуулан иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн талаарх 21 мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж, 2745 шинэ ажлын байрны захиалгыг тухай бүрд нь шинэчлэн бүртгэж ажиллалаа. 8 аж ахуй нэгж, байгууллагуудын хүний нөөцийн менежерүүдтэй хамтран ажиллаж ажил хайгч 11 иргэн, ажил олоход хүндрэлтэй 16 иргэдийг нэн тэргүүний ээлжинд ажлын байртай болгоход анхааран ажиллалаа.	100
		88	2. Мэргэжил ур чадвар дадлага туршлагыг харгалзан жил бүр дүүргийн 2500-аас доошгүй иргэдийг ажилд зуучилна.	Дүүргийн хэмжээнд сул чөлөөтэй ажлын байрны 2582 захиалга, ажил идэвхтэй хайж буй 3369 иргэдийг бүртгэж, ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхлыг харгалзан 2063 иргэнийг ажлын байранд зуучилсан. 1-19 хорооны ажил хөдөлмөр эрхэлдэггүй 748 иргэнийг түр ажлын байраар ханган ажиллуулж 30,936,000 төгрөгийн ажлын цалин хөлсийг нь олгож ажилласан байна. Мэргэжил ур чадвар, туршлагыг харгалзан хувиараа өрхийн үйлдвэрлэл эрхэлж буй 148 иргэний төсөл дэмжигдэж 209,000,000 төгрөгийн дэмжлэг олгосон байна. Энэ төслийн хүрээнд 207 иргэн байнгын ажлын байраар хангагдсан байна.	100

40	2.3.4. Ахмад мэргэжилтэн, зөвлөхүүдийн “Чингэлтэй сүлжээ”-г бий болгон, залуу ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлнэ.	89	1. Дүүрэг, хорооны ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, ажлын дадлага, туршлагатай ахмадуудын баг, бүлэг байгуулах үүсгэл санаачилгыг дэмжин ажиллана.	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ахмад мэргэжилтний зөвлөн туслах баг ажиллуулах, төсөл, хөтөлбөр бичих, хэрэгжүүлэх талаар 2 удаа сургалт явуулж, танилцуулга, мэдээлэл өгч, заавар зөвлөмж, гарын авлага материалаар ханган ажилласан. Дүүргийн 2015 оны Тэргүүний 19 дүгээр хорооны ахмадын зөвлөлийн ажлын туршлагыг гарын авлага болгон хэвлүүлж бүх хороодын Ахмадын зөвлөлийн дарга нарт тараан өгч сурталчилан ажиллалаа. 18 дугаар хорооны Ахмадын зөвлөл АДРА Олон улсын байгууллагатай хамтран “Ногоо төсөл” төсөлд 20 ахмад настанг хамруулан ажилласан. Ахмадын зөвлөлүүд, Засаг даргын ажлын албатай хамтран Хөдөлмөрийн алдар тэмдэглэх хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулж, ахмадуудын дурсамж, дурдатгалыг 18-25 насны залуучуудад ярьж таниулан сурталчилан алдаршууллаа. Уулзалт, өдөрлөгөөр төрөл бүрийн уралдаан тэмцээн, урлагийн тоглолт, нийтийн бүжиг явуулж баяраа тэмдэглэн 11 ахмадын хөдөлмөр алдрыг тэмдэглэн алдаршуулсан.	100
41	2.3.5. Эмзэг бүлгийн, ажилгүй 2500-аас доошгүй иргэдийг амьдрах орчноо сайжруулах, ногоон байгууламж нэмэгдүүлэх, мэргэжил ур чадвар шаардахгүй нийтийг хамарсан ажилд оролцуулан ажиллуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.	90	1. Эмзэг бүлгийн, ажилгүй иргэдийг амьдрах орчноо сайжруулах, ногоон байгууламж нэмэгдүүлэх, мэргэжил ур чадвар шаардахгүй нийтийг хамарсан ажилд оролцуулан ажиллуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжин тусална.	Зорилтот бүлгийн ажилгүй иргэдийн амьжиргааг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, мод тарих, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх зэрэг нийтийг хамарсан ажлыг 4 удаа зохион байгуулж 788 иргэнийг ажлын түр байраар ханган 332.288.000 төгрөгийн цалин урамшуулал олгосон.	100
2.4. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр					
42	2.4.1. “Хөгжлийн инноваци төв”-ийг байгуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.	91	1.Хөгжлийн инноваци төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд шинэ техник, технологийн мэдээ мэдээллийг хүргэж хамтран	Мэдээллийн Технологийн Үндэсний Паркийн байранд “Инноваци-Гарааны компани-2016” үзэсгэлэнгийн талаар үйлдвэрлэл эрхлэгчдэд цахим байдлаар мэдээлэл хүргэсэн. Уг үзэсгэлэнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 5 аж ахуйн нэгж оролцож	100

		<p>ажиллана.</p>	<p>инновацийн үйл ажиллагаатай танилцсан. МҮХАҮТ-аас зохион байгуулсан эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс ба Япон Улс хоорондын хэлэлцээр 2016 оны 6 дугаар сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан хэлэлцээрийн талаар дэлгэрэнгүй ойлголтыг хувийн хэвшлийнхэнд хүргэх уулзалтад “Өвсний навч” клубын төлөөллөөс оролцуулсан. Дүүргийн Кластерын төвөөс Япон Улсын худалдаа үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэдэг Чимико ХХК-тай үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажиллаж, дүүргийн оёдол эрхлэгчидтэй хамтран дэлхийн стандартад нийцсэн 42 төрлийн балетын хувцасны загварыг нь гарган 200 гаруй балетын хувцас үйлдвэрлэж тус улсад импортлосон. Цаашид захиалгын дагуу 10,000 ширхэг балетын хувцас үйлдвэрлэж импортлохоор ажиллаж байна. Хамтын түншлэлийн хүрээнд Чимико ХХК-ний төлөөлөгч нар дүүргийн арьсан эдлэл үйлдвэрлэл эрхлэгчдийн ажлын байр, бүтээгдэхүүнтэй газар дээр нь танилцан дүүргийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, Япон улс руу гаргах зорилгоор 400 гаруй бараа бүтээгдэхүүний загвар илгээснээс 80 төрлийн бараа сонгогдсон.</p>	
	92	<p>2.Жижиг дунд үйлдвэрлэлд инновацийн технологи нэвтрүүлж буй үйлдвэрүүдтэй хамтран ажиллана.</p>	<p>2016 онд дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэлийн чиглэлээр ажилладаг “Аминаарайсен” ХХК үйл ажиллагаандаа шинээр “Хүний биеийн гадаргуйн хөгжлийг тодорхойлдог 3D” технологи нэвтрүүлснээр оёдлын салбарт Монгол хүний биеийн онцлогыг тодорхойлсон стандартыг бий болгосон. Ажлын болон гоёлын хувцас үйлдвэрлэдэг “Асралт Баянхайрхан”, “Аминаарайсен” ХХК-ууд өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд туршлага, техник технологио харилцан солилцож хамтран үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна. Жижиг дунд үйлдвэрлэлд инновацийн технологи нэвтрүүлж буй талаар жижиг, дунд өрхийн</p>	100

			<p>Үйлдвэрлэл эрхлэгч 10 аж ахуйн нэгжид зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Дүүргийн жижиг, дунд өрхийн үйлдвэрлэгчид буюу улс орондоо баялаг бүтээж байгаа иргэдээ дэмжих чиглэлээр 2016.05 дугаар сард үйлдвэрийн шинэ техник технологийн туршлага судлуулах сургалтыг Тесо группын зайрмаг, шингэн сүүний үйлдвэрүүд болон Олон улсын хүүхдийн Найрамдал төвд зохион байгуулж, 100 гаруй иргэдийг хамруулсан. Үйлдвэрлэгчдэд жижиг үйлдвэрээс монгол улсын хүнсний салбарт том үйлдвэрийн хэмжээнд хүртэл хөгжиж чадсан Тесо группийн Айсмарк зайрмаг болон Милко, Зөв аарцны ундаа нэрийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн технологи, шинэ дэвшилтэд техник технологийн давуу тал болон үйлдвэрлэлийн менежмент, хүний нөөцийн бодлогын талаар танилцуулсан.</p>		
43	<p>2.4.2. Бизнес инкубатор төв болон бичил инкубаци төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоног төхөөрөмж, технологийг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p>	93	<p>1. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг бүртгэх мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж худалдан авах, түрээс, лизингийн үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлж ажиллана.</p>	<p>Тайлант хугацаанд 82 үйлдвэрлэгчдийн ажлын байраар явж судалгаа хийж, давхардсан тоогоор 287 үйлдвэрлэгчид бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэн ажилласан. Төсөл бичих төслийн сургалтанд дүүргийн 3-19 дүгээр хорооны 19 бизнес эрхлэгчдийг хамруулж сургалтанд оролцогчдын 95 хувь нь аж ахуй эрхлэлтийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтанд анх удаа хамрагдсан байна. Мөн жижиг дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа амжилттай явуулахад нь шаардлагатай ганцаарчилсан зөвлөгөөг 330 иргэнд өгч зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Аж үйлдвэрийн яамны сайдын 2015 оны 193 тушаалаар “Үйлдвэрийн нэгдсэн тооллого”-ыг Улсын хэмжээнд зохион байгуулж байна. Дүүргийн Засаг даргын А/221 тоот захирамжаар Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбар, чиглэлийг тодорхойлох “Үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан”-г бүрдүүлэх ажлын хэсгийн удирдамж, ажлын төлөвлөгөөг батлуулж 78 аж ахуй нэгжийг үйлдвэрлэлийн нэгтсэн мэдээлэлийн санд</p>	100

			<p>бүртгүүлсэн. Үйлдвэрлэгчдэд мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор холбогдох чиглэлээр зар, мэдээллийг 3 удаа SMS үйлчилгээгээр 842 үйлдвэрлэгчдэд хүргэн ажиллалаа. Төв болон салбар байрны 11 бойжигч төгсөн гарч 11 бойжигч шинээр элсэн орж хөнгөлөлттэй нөхцөл бүхий үйлдвэрлэлийн байраар хангагдан ажиллаж байна. Үүнээс төв байранд арьсан эдлэл болон нэхмэл, эсгий урлал, буриад гутал үйлдвэрлэл, зөөлөн оёдлын чиглэлээр 6, 10,11,16-р хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих БИТ-ийн салбар байранд эсгий эдлэл, зөөлөн оёдлын чиглэлээр 2, 17-р хорооны модон эдлэлийн салбар төвд 1, нийт 11 иргэн тус тус ажиллах боломжтой болсон байна. Тайлант хугацаанд 19 иргэн хөнгөлөлттэй түрээсийн байраар, 1 иргэн 3 сарын хугацаатай тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй түрээсэнд хамрагдан тус тус ажиллаж байна.</p>	
	94	<p>2. Бизнес инкубатор төвүүдийн үйл ажиллагааг сайжруулж, бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдах жижиг дунд үйлдвэрлэгчдийн тоог нэмэгдүүлнэ</p>	<p>Дүүргийн Бизнес инкубатор төвийн төв болон салбар байрнаас 9 бойжигч төгсөн гарч 9 бойжигч шинээр элсэн орж хөнгөлөлттэй нөхцөл бүхий үйлдвэрлэлийн байраар хангагдан ажиллаж байна. Тайлант хугацаанд 19 иргэн хөнгөлөлттэй түрээсийн байраар хангасан. Тайлант хугацаанд 180 үйлдвэрлэгчийн ажлын байраар явж судалгаа хийснээс шинээр 58 үйлдвэрлэгчийг мэдээллийн санд нэмж, давхардсан тоогоор 757 үйлдвэрлэгчдэд, давхардаагүй тоогоор 330 үйлдвэрлэгчдэд бизнес инкубацийн үйлчилгээ үзүүллээ. “Бизнес хөгжил”-ийн цуврал сургалтыг “Цахим маркетинг” сэдвээр 3 удаа зохион байгуулан нийт 38 үйлдвэрлэгчийг хамруулсан. Хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлд харилцан туршлага солилцсон. “Төслийн сургалт”-ийг 3 удаа зохион байгуулж, 50 үйлдвэрлэгч хамрагдлаа. “Төслийн сургалт” сэдэвт 3 удаагийн сургалтад 50 үйлдвэрлэгч хамрагдаг, хамрагдсан иргэдийн 80 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 8 хувь нь үйлчилгээний</p>	100

				салбарт, 6 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт тус тус бизнес эрхэлдэг бөгөөд 6 хувь нь бизнес эрхлэх хүсэлтэй иргэд байна. Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл 88 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 6 хувь нь албан хөдөлмөр эрхэлдэг бол үлдсэн 6 хувь нь бизнесээ эхлээгүй иргэд байна. Хүйсийн байдлаар 70.0 хувь нь эмэгтэй, 30.0 хувь нь эрэгтэй иргэд байна. Нийт сургалтад хамрагдсан иргэдээс сургалтын чанарын талаар үнэлгээ авахад 62 хувь нь маш сайн, 38 хувь нь сайн гэсэн үнэлгээг өгсөн.	
44	2.4.3. Жижиг, дунд, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах “Чингэлтэйд үйлдвэрлэв” сүлжээ, цэг “Чингэлтэйн брэнд бүтээгдэхүүн” бий болгон, гадаад дотоодын зах зээлд сурталчилна.	95	1. “Чингэлтэйд үйлдвэрлэв” сүлжээг өргөжүүлэн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах нэгдсэн сүлжээ, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтын нэгдсэн төвтэй болно.	Дүүргийн өрхийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжиж Цагаан сарын баярыг тохиолдуулан Засаг даргын Тамгын газраас ахмад настангуудад хүндэтгэл үзүүлэх ажлын хүрээнд 8 дугаар хорооны “Зөв сэтгэж-Зөв амьдарцгаая” ТББ болон 13 дугаар хорооны “Уран шаглаа” оёдлын үйлдвэрүүдээр ор хөнжлийн давуу үйлдвэрлэх ажлыг гүйцэтгүүллээ. Хүүхдийн баярын арга хэмжээнд 0-6 насны хүүхдийн бэлгэнд 17 дугаар хорооны иргэн Н.Амаржаргалын Хүүхдийн дуутай CD-ийг 2,2 сая төгрөгөөр, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлагийн наадмын арга хэмжээнд 2 дугаар хорооны иргэн Д.Эрдэнэбаяраас Мөнгөний гахайг 200,000 төгрөгөөр, гадаад дотоодын хамтын ажиллагаатай зочид төлөөлөгчдөд “Чингэлтэйд үйлдвэрлэв” бэлэг дурсгалын дэлгүүрээс 2,1 сая төгрөгний худалдан авалт, 17 дугаар хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлгээр ЗДТГ-ын харуул хамгаалалтын ажилчдын хувцасыг 195 мянган төгрөгөөр тус тус хийсэн байна. Тайлант хугацаанд 25 жижиг, дунд өрхийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний каталогийг хийж, Facebook онлайн худалдаанд 17 үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний каталогийг хийж www.ChingelteiSme.mn , www.ChdBit.mn цахим хаяг, Madeinchingeltei цахим хуудсанд байршуулсан ба үүргийн худалдаа ба онлайн	100

			<p>худалдаагаар 10,7 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг борлуулсан. “Чингэлтэйд үйлдвэрлэв” 2 салбар дэлгүүрээр бараагаа борлуулдаг үйлдвэрлэгчдийн тоо 17-оор нэмэгдэж нийт 158 үйлдвэрлэгчдийн 151,8 сая төгрөгний бараа бүтээгдэхүүн борлуулсан. Борлуулалтыг нэмэгдүүлэх, гадаадын жуулчдын татах зорилгоор “Go travel” ХХК хамтран жуулчдад зориулсан зөвлөгөө мэдээлэл, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж байна. Дүүргийн Бизнес инкубатор төв дээр өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийг сайжруулах талаар 2 удаагийн хурал зохион байгуулж нийт 80 гаруй үйлдвэрлэгчид хамрагдсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд ЗДТГ-аас “Чингэлтэйд үйлдвэрлэв” байнгын худалдааны дэлгүүрүүдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор SBN, MNC телевизүүдээр зар сурталчилгааг хийж үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан ажилласан.</p>	
	96	<p>2. Үндэсний брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих сурталчлах, туршлага солилцуулах зорилгоор дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд дэмжин оролцуулна.</p>	<p>Үндэсний үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг дэмжих зорилгоор Мишээл экспо, Дүнжингарав, Хүннү молл, дүүргийн Тусгаар тогтнолын талбай зэрэг худалдаа үйлчилгээний төвүүдэд зохион байгуулагдсан 13 удаагийн үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор дүүргийн 167 үйлдвэрлэгч оролцож, 195,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Аж үйлдвэрийн яамнаас Хүннү молл худалдааны төвд зохион байгуулсан Цагаан сар 2016 үзэсгэлэн худалдааны шилдэг бүтээгдэхүүнтэй үйлдвэрлэгчийг шалгаруулах арга хэмжээнээс дүүргийн 2 дугаар хорооны Мэргэн Тур ХХК, 11 дүгээр хорооны Уянга цогт амгалан ХХК шилдэг 9 үйлдвэрлэгчийн тоонд багтсан. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот болон Зүүн үзэмчин хошуунд болсон Цагаан сар 2016 үзэсгэлэнгүүдэд тус тус 2 үйлдвэрлэгч оролцож 2,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p>	100

				<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/294 дүгээр тушаалаар “Хичээлийн шинэ жил-2016” өргөтгөсөн худалдааг Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд Торгон хийц ХХК, МТОТ ХХК, мөн ноосон хантааз, цамц үйлдвэрлэгч Хорго мишээл ХХК, Сурагчдын хичээлийн бичиг хэрэгслийн Аржма мөнх ХХК, Тэгш Сайхан Хайд ХХК зэрэг нийт 30 гаруй иргэн, аж ахуй нэгж оролцож 53,6 сая төгрөгний борлуулалт хийгдэж иргэддээ нэг цэгийн үйлчилгээг үзүүлж, үйлдвэрлэгчдийн борлуулалтыг дэмжсэн арга хэмжээ болсон.</p>	
45	<p>2.4.4. Гэр хороодод худалдаа, ахуй үйлчилгээний төвлөрсөн бичил төв байгуулах иргэдийн хөрөнгө оруулалтын төсөл, санал санаачилгыг дэмжин ажиллана.</p>	97	<p>1. Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган иргэдийн хөрөнгө оруулалтын төсөл, санал санаачилгаар байгуулагдсан ахуйн үйлчилгээний төвүүдийг дэмжин ажиллаж ажлын байрыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 100,2 сая төгрөгийн хөрөнгөөр 10 дугаар хороонд ахуйн үйлчилгээний төв байгуулсан. Дүүргийн 18-р хорооны Ахуйн үйлчилгээний төвийг “Сүлжээт зам” ХХК нь дүүргийн ЗДТГ-тай гэрээ байгуулан ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна. Тус төв нь сардаа давхардсан тоогоор 650 гаруй иргэдэд төрөл бүрийн ахуйн үйлчилгээг үзүүлж байна. Тус төвийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор дүүргийн ЗДТГ-аас “Гэртээ харих зам” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон гэргүй тэнэмэл 78 иргэдийг бүртгэлжүүлэн халуун усны үйлчилгээнд хамруулан 844,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Дүүргийн Хөдөлмөрийн хэлтсээс “Хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 35 болон түүнээс дээш насны зорилтот бүлгийн 34 иргэнд ахуйн үйлчилгээний 5 төрлөөр 64,0 сая төгрөгний дэмжлэг олгосон. Дүүргийн өмчит 7,13,14,18-р хороодын Ахуйн үйлчилгээний төвийн ашиглалт хамгаалалтыг 2 компани, 2 иргэнд хариуцуулахаар ЗДТГ-тай гэрээ байгуулан гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. Дээрхи газрууд нь давхардсан тоогоор нийт 3100 гаруй иргэдэд ахуй үйлчилгээний нэг цэгийн үйлчилгээг үзүүллээ.</p>	100

			<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үсчин, гоо засалчдын дунд “Чингэлтэй-2016” дүүргийн үсчин, гоо засалч, хумс засалчдын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж нийт 43 аж ахуйн нэгж, иргэн 6 төрлөөр оролцож ажил мэргэжлийн аваргаа тодрууллаа.</p>	
	98	<p>2. Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг бүртгэлжүүлэн үйлчилгээний чанар стандартыг мөрдүүлэн ажиллана.</p>	<p>Тайлант хугацаанд Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 70 иргэн аж ахуйн нэгжийг Цагдаагийн хэлтэстэй хамтран стандартанд нийцсэн камержуулалтад хамруулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 07 тоот тогтоолын дагуу “Үйлчилгээ эрхлэх гэрээ” байгуулан, байгуулан мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Ахуй үйлчилгээний салбарын шилдэг байгууллага тодруулах, мэдээллийн санг бүрдүүлэх, иргэдийн амьдрах орчны зураглалд оруулах зорилгоор дүүргийн 1-5 дугаар хороодод ахуй үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 310 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаатай танилцан, бүртгэлжүүлж мэдээллийн санд бүртгэсэн. Автомашин угаалгын чиглэлээр үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд “Авто тээврийн тухай хууль” бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг сурталчлах, эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор авто үйлчилгээ эрхлэгч дүүргийн 12 иргэн, ААНБ-дад хамтарсан сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн түвшинг дээшлүүлсэнийг баталгаажуулсан гэрчилгээ олголоо. Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 1-6 дугаар хороо буюу төвийн бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг 520 гаруй аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаатай танилцан бүртгэлжүүлэн мэдээллийн санд бүртгэсэн. Садар самуунтай тэмцэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс, дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн “Сэтгэл амар төв”-тэй хамтран массажны</p>	90

				чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 8 газрын 12 ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж цагаан хуудас олгож дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн “Сэтгэл амар төв” тогтмол хамтран ажиллаж байна.	
2.5 Хүнсний аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал					
46	2.5.1. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын үр нөлөөг сайжруулна.	99	1. Мэргэжлийн Хяналтын байгууллагаас хийгдэж буй хяналт, шалгалтын ажлын үр дүнд дүн шинжилгээ хийж хууль, стандартыг мөрдүүлэн ажилласанаар эрсдэлтэй үйл ажиллагаа эрхлэгчийн тоог бууруулан ажиллана.	Тайлант хугацаанд МХЕГ-аас батлагдсан-24, НМХГ-ын даргын баталсан-17, ЧД-ийн ЗДТГ-ын баталсан-3, дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын баталсан 47 удирдамжаар хяналт шалгалт хийж, танилцуулга-98, улсын байцаагчийн дүгнэлт-179 шинжилгээний-50, ажил үйлчилгээний-12, улсын байцаагчийн акт 49 улсын байцаагчийн албан шаардлага-159, улсын байцаагчийн зөвлөмж-93 гаргасан байна. Хяналт шалгалтаар 49 байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагад-15,887,200 төгрөгийн, 21 албан тушаалтанд 3,690,000 төгрөгийн, 73 иргэнд 7,310,000 төгрөгийн нийт 28,239,200 төгрөгийн шийтгэвэр ногдуулж, 26,887,200 төгрөгийг бүрэн барагдуулсан.	100
47	2.5.2. Архи, тамхи худалдан борлуулахад тавих хяналтыг чангатгаж, архи тамхигүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна.	100	1. Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах, хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлэх шалгалтыг явуулна.	НИТХТ-ийн 2015 оны 12 дугаар сарын 205 тоот тогтоолын дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах ажлыг Нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн ажилтнууд гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 92 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл сунгагдан, шинээр 4 аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгож, 8 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн батласан удирдамжийн дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад аттестатчиллын шалгалтыг 2016.07.01-нээс эхлэн зохион байгуулах болсонтой холбогдуулан согтууруулах ундаа худалдах, түүгээр	100

			<p>үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 100 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох стандартуудыг сурталчлан таниулахаар сургалтыг зохион байгуулсан. Мөн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй давхардсан тоогоор нийт 530 гаруй аж ахуйн нэгжийн удирдлагуудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран 3 удаагийн сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан.</p>	
	101	<p>2. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгоно.</p>	<p>Нийслэлийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнтэй хамтран “Тамхигүй Улаанбаатар” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, эрчимжүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж сургалтанд хороодын Засаг дарга, зохион байгуулагч, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн нэгдэл болон өрхийн эмнэлгийн нийт 30 гаруй ажилтан, албан хаагчид оролцсон. Сургалтаар Тамхины хяналтын тухай хуулинд орсон нэмэлт өөрчлөлтүүд, тамхины хор хөнөөлтэй тэмцэх, сэргийлэх стратеги чиглэлүүд, хуулийн хэрэгжилтийг хангахад нөлөөлж буй хүчин зүйлүүд, хороодын үүрэг оролцоо зэрэг сэдвүүдээр мэдээллийг өгсөн. “Тамхины утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эрчимжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2016 оны А/191 тоот захирамжаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын хэсэг болон үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний дагуу хороо тус бүр тодорхой ажил зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дүүргийн ГХУССЗ-өөс дүүргийн хэмжээнд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 3-н сарын аян”-г зарлан аяны хүрээнд “Эрсдэлгүй ирээдүйн төлөө-Хамтдаа” сургалтыг 17, 37, 39, 49, 57, 61, 72, 117-р сургуулийн ахлах ангийн 900 гаруй сурагчдын дунд зохион байгуулсан. Энэхүү аяны хүрээнд хороо тус бүр өөрийн нутаг дэвсгэрт үйл</p>	100

			ажиллагаа эрхлэж буй ААН, иргэд, ЕБС-ийн сурагчид, өрхийн эмнэлэг зэрэг хувийн хэвшлийн болон төрийн байгууллагуудын дунд өдөрлөг, сургалт, уралдаан тэмцээнийг зохион байгуулж 13-н хороо, 6-н сургууль, 10 цэцэрлэгийн баг хамт олон амжилттай аяныг хэрэгжүүлсэн. Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах Ажлын хэсэг нь 2016 оны эхний хагас жилийн байдлаар 4 удаа хуралдаж Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг үндэслэн 18 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг хэлэлцэн шаардлага хангасан 32 газарт тусгай зөвшөөрлийг хуулийн хугацаанд олгон дүүргийн төсөвт 8,0 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан. Тамхины хяналтын тухай хуулийн хүрээнд УБ хотын ЗАА-ны Ерөнхий Менежерийн тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг 123 ТҮЦ –д хуулийн хэрэгжилтийг шалган 196 хайрцаг тамхи хураан авч 855,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч ажилласан.		
48	2.5.3. Хоол, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдааны цэг салбаруудад тавигдах стандарт, эрүүл ахуйн шаардлагыг мөрдүүлж, түүнд тавих хяналтыг сайжруулна.	102	1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд сурталчлах хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн арга хэмжээ, сургалт сурталчилгаа зохион байгуулна.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг худалдааны төв, хүнсний захуудын удирдлагуудад хүнсний бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох тогтолцоох нэвтрүүлэх, бүтээгдэхүүний буцаалт болон тогтмол авалтын бүртгэл хөтлөх, түүний ач холбогдол, хэрэглэгчийг үнэн зөв мэдээллээр хангахад аж ахуйн нэгж, иргэний үүрэг, хариуцлага зэрэг сэдвүүдээр Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газартай хамтран сургалт зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан. Сургалтанд худалдааны төв, хүнсний зах, шатахуун түгээх станцын дэргэдэх хүнсний дэлгүүрүүдийн эзэд нийт 15 гаруй аж ахуйн нэгж оролцсон. Дүүргийн төрийн бус өмчийн 17 цэцэрлэгийн тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Үйлдвэрлэл Технологийн Сургууль, Хоол зүй шим	100

			<p>судлалын монголын нийгэмлэгтэй хамтран 3 өдрийн онол, дадлагын сургалтыг зохион байгуулж, дадлагын хичээлээр 20 гаруй нэр төрлийн хоол, зуушийг үйлдвэрлэлийн технологийн зааврын дагуу шимт чанар, биологийн үнэт чанар сайтай хоол үйлдвэрлэх дадал эзэмшүүлж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. “Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд шалгалт хийх” удирдамжийн хүрээнд дүүрэгт байрладаг мах, махан бүтээгдэхүүний 2 үйлдвэрийн 4 ажилтанд байгууллагын сургалтыг зохион байгуулж, гарын авлага материалаар хангасан. “Худалдаа үйлчилгээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөлтөнд хяналт тавих нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 60 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцон мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангалаа. Монголын жижиг дунд дэлгүүрүүдийг дэмжих холбоотой хамтран “Хамтын түншлэл-Хамтын хөгжил сэдэвт сургалтыг зохион байгуулж, 20 аж ахуй нэгжийн удирдлагуудыг хамруулж, 12 аж ахуйн нэгжийн удирдлагуудыг холбооны гишүүнээр элсүүлэн батламж гардуулсан. Дүүргийн 6,15,16,17 дугаар хороонд хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд “Хууль сурталчлах” сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт нийт 110 аж ахуйн нэгж, иргэдийн төлөөллөл оролцлоо. Дүүргийн Худалдаа, Үйлчилгээний Зохицуулах Зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу ЧДХЭАХН, хороодын ажлын албатай хамтран төвийн хороодын 160 гаруй хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS4946:2005”, “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам”-ын 5.1.4 дэх заалтын хэрэгжилт “Бохир усан дахь өөх, тос баригч төхөөрөмж, техникийн ерөнхий шаардлага MNS5975:2009” стандартын дагуу сантехникийн шугам</p>	
--	--	--	--	--

				шаардлага хангасан өөх тос баригч суурилуулах, ажлын байрны агааржуулалтын систем дуу чимээ намсгагчийг шаардлагад нийцүүлэн хийсэн байдалд үнэлэлт өгч, илэрсэн зөрчлийг арилгуулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.	
		103	2. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй худалдааны төв, хүнсний захуудад тухайн салбарт мөрдөгдөж байгаа “Хууль, журам, стандарт”-ыг сурталчлах өдөрлөг зохион байгуулна.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс албан даалгавар гаргуулан хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Эрдэнэбулган ХХК-ний худалдааны төв нь үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөн шинэ технологи нэвтрүүлэн МАЛЛ хэлбэрийн үйлчилгээг үзүүлэхээр тохижилт бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Мөн Хүчит шонхор хүнсний зах нь 2 байрандаа түрээслэгчдийн ая тухтай орчин бүрдүүлэхээр засварын ажлыг гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 5 худалдааны төвүүд нь мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2636 түрээслэгчдээс хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1520 гаруй түрээслэгч нарт тухайн салбарт мөрдөгдөж байгаа хууль, журам, стандартыг сурталчлах ажлыг зохион байгуулсан.	90
49	2.5.4. Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах нөхцөлийг бүрдүүлэн, газар тариалангийн аймаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.	104	1. Шинэ ургацын ногоог нийслэл, дүүргийн иргэдэд хүргэх үүднээс худалдан борлуулах цэгийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Дүүргийн 11 дүгээр хорооны Нуурын 11-204 тоотод бүртгэлтэй Төв аймгийн Эрдэнэ суманд жилийн 4 улирлын турш хүлэмжийн аж ахуй эрхлэн жимс жимсгэнэ, нарийн ногоо тариалдаг “Ногоон сор” ХХК-ний экологийн цэвэр бүтээгдэхүүнийг цаг алдалгүй иргэдийн гарт хүргэх үүднээс хамтран “БАЙГУУЛЛАГА ХУДАЛДААГ” зохион байгуулж 40 гаруй гүзээлзгэнэ, 26 тасалгааны гүзээлзгэний үрсэлгээг борлуулсан. “Гацуурт” ХХК, “Дельта Холдинг” ХХК-тай хамтран Монгол хөрсөнд ургасан төмс, байцаа, лууван зэрэг хүнсний ногоог “ТАРИАЛАНЧААС ТАНЫ ГАРТ-МОНГОЛ БАЙЦАА” арга хэмжээг өрнүүлж дүүргийн иргэдэд хурдан шуурхай хүргэх үүднээс Алтжин	100

			<p>худалдааны төв, Барилгачдын талбай, 7 буудал, 17-р цэцэрлэгийн урд талбай, Баянбүрдийн талбайд 4-р сард зохион байгуулж нийт 108 тн хүнсний ногоо борлууллаа. Бүх нийтийн мод тарих өдөр болон иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс АДРА олон улсын байгууллагтай хамтран дүүргийн Барилгачдын талбайд хөтөлбөрт хамрагддаг зорилтот бүлгийн 12 өрхийн амжиргаанд дэмжлэг үзүүлэх үүднээс жимс, жимсгэний модны суулгац, үр үрсэлгээ, тасалгааны цэцгийг борлуулах үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 13,02 сая төгрөгний борлуулалтыг хийлээ. "Хүлэмжийн ШИНЭ ногооны АМТ" нэртэй эх орны хөрсөнд ургасан шинэ ногооны үзэсгэлэн худалдааг 6-р сард Барилгачдын талбайд зохион байгуулж, 30 гаруй аж ахуй нэгж оролцлоо. Газар тариалан эрхлэгчдийг дэмжих, нийслэлийн иргэдэд худалдаа үйлчилгээг ойртуулж шинэ ургацын ногоогоор хангах ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд 1, 2, 4, 5, 16, 18-р хороодод нийт 7 цэгт Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн 710 гаруй иргэд эх орны хөрсөнд ургасан төрөл бүрийн хүнсний ногооны үзэсгэлэн худалдааг гарган нэг цэгийн үйлчилгээг үзүүлж байна. "Адра-Монгол" олон улсын байгууллагын "Өрхийн тогтвортой тариалан төсөл"-ийг Нийслэлийн 5 дүүргийн 1100 өрхөд хэрэгжүүлж эхэлсэн. Уг төсөлд Чингэлтэй дүүргийн 14, 17, 18, 19 дүгээр хорооны 220 өрх Тусгаар тогтнолын талбайд "Эко хүнсний ногоо" сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж давхардсан тоогоор 680 гаруй иргэд үйлчлүүлэн 1,6 сая төгрөгийн борлуулалт хийгдэн өрхийн тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжсэн арга хэмжээ болсон.</p>	
	105	2. Дүүргийн газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллана.	Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Монголын хүнсний ногоочдын холбоотой хамтран Улаанбаатар хот дах "Хүнсний ногоочдын сургалт, уулзалт, зөвлөгөөн"-ийг зохион байгуулж дүүргийн газар тариалан эрхлэгч 24 иргэнийг хамруулан НҮХАА	100

			<p>газраас Хаврын тариалалтын үед хамтран ажиллах тухай ярилцан санал солилцлоо. Дээрх ажлын үр дүнд дүүргийн Засаг даргын Тамгын газраас Тарвагтайн аманд тариалан эрхлэгч 5 бүлэгт тус тус 200 мянга, нийт 1,0 сая төгрөгний мөнгөн тусламж үзүүлж өрхийн тариалан эрхлэгч болон тариалан эрхлэх сонирхолтой нийт 23 иргэдэд НҮХАА-н газартай хамтран үнэ төлбөргүй 3 нэр төрлийн нарийн ногооны 22 кг үрийг өрхийн хэрэгцээнд тариалах, амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон. Үрсэлгээ авсан иргэдээс 10 иргэн Тарвагтайн амны 1 га талбайд, 13 иргэн 4 га буюу хашаандаа, нийт 5 га талбайд тариалалтын ажлыг эхлүүлээд байна. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газраас Тарвагтайн аманд тариалан эрхлэгч 3 бүлгийн 100 гаруй тариаланч иргэдийн үйл ажиллагааг дэмжин 2,5 сая төгрөгийн мөнгөн тусламж үзүүллээ. Швейцарын хөгжлийн агентлагын санхүүжилтээр “Монгол ногоо” төслийн 3-р бүрэлдэхүүн хэсэг хэрэгжиж дүүргийн газар тариалан эрхлэгч иргэдэд “Хүнсний ногоо”-ны сургалтыг Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Монголын Фермер Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран зохион байгууллаа. Энэхүү сургалтыг иргэдийн амжиргааг дээшлүүлэх, хүнсний ногоо тариалах арга барилд сургах, өрхийн тариалалтыг хөгжүүлэх үүднээс 3 үе шаттай зохион байгуулахаар төлөвлөөд байна. 1-р шатны “Хүнсний ногоо тарих аргачлал” сургалтыг 5-р сарын 04-ний өдөр газар тариалан эрхлэгч 50 иргэдэд танхимын сургалтыг дүүргийн хурлын танхимд зохион байгуулж талбайн сургалтыг дүүргийн 18-р хорооны иргэн н. Бямбажавын хашаанд зохион байгууллаа. Сургалтын үеэр өрх толгойлсон эмэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны түвшин доогуур 23 иргэдэд 6 төрлийн /Төмс, лууван, хүрэн манжин, шар манжин, бууцай, урт сонгино/ хүнсний ногооны үрний дэмжлэг үзүүллээ. 2-р шатны “Ил талбайн төмс</p>	
--	--	--	--	--

				хүнсний ногоо болон хүлэмжний ногооны арчилгаа, өвчин хортон тэмцэх арга” танхимын сургалтыг Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд, талбайн сургалтыг дүүргийн 9-р хорооны иргэн Р.Алтантүлхүүрийн хашаанд зохион байгуулж нийт 22 гаруй иргэд оролцсон. Сургалтанд оролцогсдод “Гэр бүлээрээ хамтран ажиллацгаая” ном, гарын авлагаар ханган ажилласан.	
50	2.5.5. “Малын эрүүл мэнд” хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	106	1. Мал, амьтныг вакцинжуулалтад хамруулан НИТХТ-н 2015 оны 85 дугаар тогтоолын дагуу зөвшөөрөгдсөн бүсэд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна.	<p>Дүүргийн Засаг даргын 2016 оны А/202 дугаар захирамжаар хонины гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцинжуулалтын ажлыг Онцгой байдлын хэлтэс, Мал эмнэлэг үржлийн алба “Содхан” ХХК, хороодтой хамтран зохион байгуулсан. Вакцинжуулалтад нийт 4 өрхийн 124 хонийг хамрууллаа. Дүүргийн хэмжээнд нийт 6 төрлийн вакциныг 5683 малд хийснээс /Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 156 малд, Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 823 малд, Дуут хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 505 малд, Цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 341 малд, Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 530 мал, 2460 нохой, Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 3231 мал, амьтанд/ хийж гүйцэтгэлээ. Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын хүрээнд МЭУАлба мал бүхий айл өрхийн хашаа, өтөг бууц зэрэг 6800 м2 талбайд, худалдааний төв, заал лангуу 10100 м2 талбайд нийт 16900 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт, 3670 кг мах махан бүтээгдэхүүн, 2685 л сүү, сүүн бүтээгдэхүүнд шинжилгээ хийж баталгаажилт олгосон. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 85-р тогтоолоор батлагдсан “Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”-ыг хэрэгжүүлж ажиллах тухай Нийслэлийн Засаг даргын 2016 оны 01/1209 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу холбогдох хэлтэс албадаас</p>	100

				хэрэгжүүлэх ажлын саналыг авч дүүргийн Онцгой комиссын даргын 2016 оны 13 дугаар тушаал батлагдаж 10-р сарын 01-ний өдрийг хүртэл мал бүхий 63 айл, өрхүүдийг хориглосон бүсээс малаа гарган нүүлгэн шилжүүлж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдэгдэл заавар зөвлөгөөг хүргүүлж 14 өрх малаа бүрэн гаргаж 24 өрх малаа хэсэгчлэн гаргаж 1500 малаас 52 өрхийн 958 мал 358 төл нийт 1296 мал үлдээд байна.	
--	--	--	--	---	--

ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЕЛЭЛТ	ХУВЬ
--	------------------------------------	---------	------

ГУРАВ. ТОХИЛОГ ОРЧИН- ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

3.1 ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА

51	3.1.1. Улс, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, экологийн тэнцвэрт байдалд нийцүүлэн дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г жил бүр тодотгон хэрэгжүүлнэ.	107	1. Дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнана.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 07 дугаар тогтоолоор 2016 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулан, төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэг цэгээс түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө 90 хувийн хэрэгжилттэй байна.	90
		108	2. Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн шугам сүлжээнд холбогдох иргэдийн үүсгэл, санал, санаачилгыг дэмжин ажиллана.	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэх Сэлбэ голын дагуух 17 км дугуйн замын трасст өртсөн иргэн, аж ахуй нэгж байгууллагын судалгааг гарган, нийслэлийн Өмчийн харилцааны газрын Газар чөлөөлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдэд цэцэрлэг, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, дулааны станцын барилга мөн авто зам болон бусад инженерийн дэд бүтцийн шугам барих бөгөөд энэ шугамын трасс нь Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороодын нутаг дэвсгэр дээр баригдахаар инженер, техникийн болон нийгэм, эдийн засгийн шийдэл гарсан болно. Одоогоор дүүргийн 18	100

				<p>дугаар хорооны нутаг дэвсгэрт уг төслийн ажилтай холбоотойгоор авто зам тавигдахаар төлөвлөгдөж трасст өртсөн нийт 16 нэгж талбарын өмчлөгч иргэдэд мэдэгдлийг тарааж судалгааг гаргаад байна. Чингэлтэй дүүргийн 17, 18 дугаар хорооны нутаг дэвсгэр “7 Буудлаас Чингэлтэйн эцэс хүртэлх 3,3 км авто замын өргөтгөл шинэчлэлт”-ийн ажлын хүрээнд хашаа татах 22 нэгж талбар, үл хөдлөх хөрөнгө буулгаж, 18 нэгж талбарыг чөлөөлөн нөхөн олговор өгч ажиллалаа. Дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдах Бага сургууль цэцэрлэгийн цогцолборын барилгажих талбайд нийт 8 иргэний нэгж талбар өртөж байгаа ба иргэдийн нөхөх олговрын үнэлгээг хийлгэсэн.</p>	
52	<p>3.1.2. Иргэдэд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх болон иргэдийн газраа эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилгыг дэмжин, газрын харилцаатай холбоотой мэдээллийг нээлттэй ил тод болгоно.</p>	109	<p>1. Газар өмчлөлийн талаар нарийвчилсан мэдээлэл бүхий сан үүсгэж иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.</p>	<p>Газраа өмчилж авах, хамтран өмчлөгч хасуулах, кадастрын зурагт өөрчлөлт оруулах зэрэг асуудлаар хүсэлт ирүүлж байгаа 520 иргэний материалыг GOOGLE-EARTH программын зурган мэдээллийг ARCGIS-ийн зурагтай давхцуулан шалгаж үзээд шаардлага хангасан иргэдийн өргөдлийг LPIS программ дээр газар өмчлөлийн захирамжийн төсөлд бэлдэн Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Газар өмчлөлийн комиссын хурлаар хэлэлцүүлэн захирамж гаргуулан газар өмчлөх шийдвэрийг олгож байна. Тайлант хугацаанд нийслэлийн Засаг даргын 2016 оны А/32, А/201, А/332, А/380 тоот захирамжуудаар нийт 360 иргэний газар өмчлөлийн асуудлыг шийдвэрлэлээ. Одоогийн байдлаар газраа өмчилж авах хүсэлтэй 60 иргэний материал, өмчилсөн газраасаа хамтран өмчлөгч хасуулах, кадастрын зурагт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан 300 иргэний материалыг хүлээн авч “Газар өмчлөлийн шийдвэрийн төслийг магадлах ажлын хэсгийн хуралдаан”-д оруулахаар бэлтгээд байна. Нийслэлийн Засаг даргын захирамжаар хамтран өмчлөгч хасуулсан болон кадастрын зурагт өөрчлөлт оруулсан захирамжийн хуулбар авах хүсэлт гаргасан 139 иргэнд үйлчилгээ үзүүлээ. 2016 оны</p>	100

			эхний хагас жилийн байдлаар нийслэлийн өмчийн харилцааны газрын мэдээлэл технологийн хэлтэст бүртгэгдсэнээр тус дүүргийн бүртгэлтэй 4245 иргэд цахимаар газар өмчлөх хүсэлтээ өгч сонгогдсон байна.		
		110	2. Дүүргийн иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг хуулийн хүрээнд үргэлжлүүлэн зохион байгуулж, зуслангийн ногоон бүсэд газар өмчлүүлэх ажлыг эхлүүлнэ.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 10/39 тоот “Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд газар өмчлүүлэх газрын байршил, хэмжээг тогтоох” тухай тогтоолоор иргэнд өмчлүүлэх газрын байршил хэмжээг тогтоож, 2014-2016 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар олголт хийгдэхээр төлөвлөгдсөн байршилд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон зураг төслийн ажил хийгдсэн. Тус дүүрэгт Жигжид, Яргайт, Ар согоот, Гүнт, Ойн булаг, Шадивлан, Яргайтын богино зэрэг 7 аманд тус тус газар өмчлөлийн ажил явагдах ба зөрчилгүй шийдвэрлэх боломжтой 186 иргэний газар өмчлөлийн өргөдлийг хүлээн авч эхэлсэн.	100
		111	3. Газар эзэмшиж, ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэн, газрын төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн Өмч, Газрын харилцааны алба 2016 онд газрын төлбөрийн орлогоос нийслэлийн төсөвт 280.0 сая.төг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж тайлант хугацаанд газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөнд нийслэлийн төсөвт 210,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 205,6 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 98 хувьтай байна. Тайлант хугацаанд дүүргийн Засаг даргын 56 удаагийн захирамж гарч мэдээллийн санд газрын эрх баталгаажих, газрын эзэмших эрхийн нэр шилжих, талбай өөрчлөх, хугацаа сунгах зэрэг нийт 791 нэгж талбарыг мэдээллийн санд оруулсан.	100
53	3.1.3. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөлтийн дагуу төвийн хороодыг дахин барилгажуулах ажлыг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлж эхэлнэ.	112	1. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөлтийн дагуу хуучин орон сууцыг барилгажуулах, дахин төлөвлөлтөд оруулах ажилтай холбоотой судалгаа, мэдээ мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлж хамтран ажиллана.	Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөлтийн дагуу хуучин орон сууцыг барилгажуулах, дахин төлөвлөлтөд оруулах ажлын хүрээнд холбогдох судалгааг Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газарт хүргүүлсэн.	100

54	3.1.4. Олон жил болсон орон сууцны байруудын дээвэр, фасад, цахилгаан шат, инженерийн шугам сүлжээг засварлах, шинэчлэх, хонгилын системд оруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	113	1. Олон жил болсон орон сууцны байруудын дээвэр, дулаалга, фасадны засварын ажлуудыг Улс, Нийслэл, Дүүргийн хөрөнгө болон иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын хөрөнгө, санаачлагаар хийж гүйцэтгэнэ.	Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 4 дүгээр хорооны 30/а байрны фасад засварын ажлыг “Урт булаг” ХХК 38,9 сая төгрөгөөр гүйцэтгэсэн. Мөн 6 дугаар хорооны 33/а байрны фасад засварын дутуу ажлыг “Их галдай” ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1-р хорооны 2-р 40.0-тын 40 дүгээр байрны фасад засвар, 1-р хорооны 39-р байрны фасад, 4-р хорооны 39-р байрны дээврийн засварын ажлууд эхлээд байна. Дүүргийн 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж байгаа 4 дүгээр хорооны 2/а байрны фасад засварын ажлыг “Шилдээд” ХХК 64,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2-р хорооны 27-р байрны дээврийн засварын ажлыг “Инновэйшнлогик” ХХК 42,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	100
		114	2. Дүүргийн нутаг дэвсгэрийн газар доорх инженерийн шугам сүлжээний салбар шугамын төлөвлөлтийн зураг төсвийг хийлгэж, аюулгүй байдлыг хангах асуудлаар холбогдох газруудтай хамтран хяналт тавьж ажиллана.	Дүүргийн 4, 5, 6 дугаар хороонд байрлах 94 байрны 5096 гаруй өрх, 500 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудын халаалт, хэрэгцээний халуун, хүйтэн усыг тасралтгүйгээр найдвартай түгээх, бохирыг татан зайлуулах цахилгааны ерөнхий цитээр дамжуулан хэрэглэгчдэд цахилгаан түгээх мөн инженерийн шугам сүлжээ тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тооцоо тохируулга байнгын хийж хэрэглэгчдэд шаардлага хангасан үйлчилгээ үзүүлж 15,6 сая төгрөгийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Шуурхай үйлчилгээний хэсэгт тухайн сард оршин суугч иргэд ААН байгууллагаас 981 дуудлага санал хүсэлт ирж тухай бүрт барагдуулж ажиллалаа. Дүүргийн 1-4-р хорооны Орон сууцны 96 байрны узель, 19-н ХЦТ болон тоног төхөөрөмжийн урсгал засварын ажил 100 %-тай байна.	90
55	3.1.5. Хороолол доторх гражуудыг цэгцэлж, газар доогуур далд буюу давхар	115	1. Хот, дүүргийн өнгө үзэмжид сөрөг нөлөөлөхүйц хашаа, граж, ТҮЦ, павильон зэрэг үйлчилгээний	Дүүргийн хэмжээнд “Явган зам” арга хэмжээний хүрээнд одоогийн байдлаар нийт 16 хороодод Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 9519,2м2 талбайд,	100

	зогсоолуудыг барьж, "Хашаа", "Явган зам" арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулна.		цэгүүдийг цэгцлэх зорилгоор "Хашаа", "Явган зам" арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулна.	ОНХС болон Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 9114м2 талбайд нийт 18633м2 талбайд тус тус явган зам хийгдсэн.	
56	3.1.6. "Гэр хорооллын хөгжлийн стратеги" төслийн хүрээнд гэр хороодыг орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар эхлүүлж, "Нэг өрх-Нэг орон сууц" загвар төсөл хэрэгжүүлнэ.	116	1. Дахин төлөвлөлттэй уялдуулан хувийн орон сууц барих "Нэг өрх-нэг орон сууц" загвар төслийг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	Тусгаар тогтнолын талбайд "Изо Хаус" ХХК-тай хамтран канад модон хийцтэй угсармал зөөврийн амины орон сууцны загвар гарган 3000 гаруй иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Уг ажлын хүрээнд зөөврийн амины орон сууц худалдан авах гэрээг 5 иргэн байгуулсан ба барилгын халаалт, хөргөлт, хүлэмжийн аж ахуйн дулаан хангамжинд хэрэглэх боломжтой нарны эрчим хүчнээс дулаан, цахилгаан үйлдвэрлэх эко технологи бүхий төвийн системд холбогдоогүй эрчим хүчний үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрийн уурын систем, халаалтын туслах үүсвэр бий болгох төслийг дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хот байгуулалт зураг төслийн хүрээлэн ХХК-тай хамтран иргэд олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мөн Хайлаастын 72 дугаар сургуулийн орчим дахин төлөвлөлт хийж буй "Асар өргөө" ХХК-тай дүүргийн Засаг даргын Тамгын газраас төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлын хүрээнд гэрээ байгуулан ажиллаж байна. 19 дүгээр хороо Ар согоотын зусланд 1 иргэнтэй орон сууц барихад хамтран ажиллах гэрээ байгуулсан.	90
3.2. Хот тохижилт, дэд бүтэц					
57	3.2.1. Нийслэлийн авто замын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэн, орон сууц, гэр хороодын болон нийтийн эзэмшлийн гудамж талбайн авто зам, явган замыг засварлан шинэчилнэ.	117	1. Дүүргийн орон сууцны хороолол дундах авто замын шинэчлэл, засварын ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрийн авто замын шинэчлэл, засварын хүрээнд нийслэлээс эрх шилжиж ирсэн 500 сая төгрөгийн засвар шинэчлэлийн ажлыг Нийслэлийн авто замын газраас гэр хорооллын бүс рүү шилжүүлсэн бөгөөд 12 дугаар хороо 220 дугаар цэцэрлэг, 16 дугаар хороо 221 дүгээр цэцэрлэг, 16 дугаар хороо 49, 59, 37 дугаар гудамжууд болон тус цэцэрлэгүүд рүү авто зам тавигдахаар төсөвлөгдсөн бөгөөд "Өлзийхутагийн наран" ХХК хийж гүйцэтгэж нийт 542у/м авто зам тавьсан.	90

		<p>118</p> <p>2. Чингэлтэйн гудамж, 7 буудлын уулзвараас Чингэлтэйн эцэс хүртэлх 3,3 км авто замыг өргөтгөх ажлыг үргэлжлүүлэн хийж дуусгана.</p>	<p>Дүүргийн 18, 17 дугаар хороо Чингэлтэйн гудамж, 7 буудлын уулзвараас Чингэлтэйн эцэс хүртэлх 3,3 км авто замын өргөтгөлийн ажлыг “Экспресс зам” ХХК нийслэлийн төсвийн 4.923,8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.</p>	<p>100</p>
		<p>119</p> <p>3. Гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдээгүй газарт шинээр авто зам барих, гол замаас сургууль, цэцэрлэг, хороод руу салсан замын ажлын зураг төслийг боловсруулж, ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 10 дугаар хороо, Самбалхүндэвийн эргэмжийн газрын авто замаас Ундром дэлгүүр хүртэлх 600у/м авто зам, 16 дугаар хороо, Хайлаастын эцсийн Хаан банктай уулзвараас баруун тийш Гахайн байрны авто замтай холбох 650у/м авто замыг Тохижилт Үйлчилгээ ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр 13 дугаар хорооны 17–р сургуулийн арын зам буюу 9-р гудамжинд тавих авто замын ажлыг 41,3 сая төгрөгөөр “Квадровэй” ХХК, 18 дугаар хороо Яргайтын 16 дугаар гудамжинд 360 м2 байгалийн чулуун хучилттай авто замын ажлыг 59,8 сая төгрөгөөр “Тотал инж” ХХК хийж гүйцэтгэлээ. 14 дүгээр хорооны байрлуу явсан замын орц гарцыг сайжруулах ажлыг Дүүргийн төсвийн хөрөнгөөр Эф Өү Эм ХХК 37,3 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн бөгөөд 605м2 бетонон зам, 144м2 явган хүний зам тус тус хийж гүйцэтгэлээ. 16 дугаар хороо Согоотын 14 гудамж, 14 дүгээр хороо 126 дугаар цэцэрлэгийн урд талд, 15 дугаар хороо Жаргалантын 1 дүгээр гудамжуудад ОНХС-гийн хөрөнгөөр Эко тогтол ХХК нийт 291,3 сая төгрөгөөр 371у/м байгалийн чулуун зам, 820м2 явган зам хийж гүйцэтгэлээ. 17 дугаар хороо Сурагчийн 49 дүгээр гудамжны гүүрнээс Чингэлтэй авто замтай холбох 200 у/м бетонон замын ажлыг Дүүргийн төсвийн хөрөнгөөр Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ ХХК 62,8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн бөгөөд 310м2 эко хавтан, 412м2 явган зам тус тус хийж гүйцэтгэлээ. Чингэлтэй дүүргийн ТҮ ХХК нь тус дүүргийн 10 дугаар хороо, Хүчит шонхор захын урд талын бетон явган зам болон авто зогсоолын ажил нийт бетон 1158,6м2, эко хавтан 573м2, явган зам</p>	<p>100</p>

				5,4м2, байгалийн чулуу 18,5м2 талбайд тус тус хийж гүйцэтгэлээ.	
58	3.2.2. Айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн ханган, дулааны зарим хэрэглээг, цахилгаанаар хангах нөхцөлийг бүрдүүлэн дэд станц, шугамын өргөтгөл шинэчлэлийг хийнэ.	120	1. Дүүргийн гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг эрчим хүчээр бүрэн хангах, хүчдэлийн уналттай айл өрхийн цахилгаан эрчим хүчний хүчдэлийн хангамжийг сайжруулна.	Дүүргийн нутаг дэвсгэрийн гэр хорооллын иргэдийг аюулгүй, амар тайван орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн 19 дүгээр хороонд 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр 19-р хорооны Ар согоотын гудамжинд АТП-183-аас 44 ширхэг гэрэлтүүлэг хийх 2.2 кВт хүчин чадлын тооцоо, зураг төсөв хийгдэж дууссан. 7-р хороо, Зурагтын шинэ эцсээс 10-р хороо, Далан давхарын шинэ зам хүртэл авто болон явган замын ажлын трассд орсон АТП-1650 дэд станц, 0,4кВ шугам шилжүүлэх техникийн нөхцөл гаргуулсан. Мөн Дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороо, Согоотын 89- 90 дүгээр гудамжны айл өрхийн цахилгааны эрчим хүчний уналтыг сайжруулах ажлыг нийслэлийн инженерийн байгууламжийн хэлтэст 2016 онд хийгдэх зураг төсөвтэй ажлын төлөвлөгөөнд оруулсны дагуу АТП-10/0,4кВ 160кВа, 10кВа ЦДАШ 0.46км, газар доогуур 0.22км, 0.4кВ ЦДАШ 458метр шугам шинээр хийх ажлыг 96.768.300 төгрөгний санхүүжилтээр “Ханлиг тайшир илч” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Мөн 17 хороо Шар хагтын аманд 1400 метр СИП кабель, төмөр бетон тулгуур 32ширхэг, 1 ширхэг шить ком тоноглох ажлыг Чингэлтэй дүүргийн ТҮК 28.8 сая төгрөгний төсөвт өртөгтэй хийж ашиглалтанд оруулсан болно. Мөн Захирагчийн ажлын албаны инженерийн байгууламжийн хэлтэст, “УБЦТС” ХК-ний Чингэлтэй хариуцсан инженер, Дүүргийн дэд бүтэц, тохижилтын хэлтэс, хороодын Засаг дарга нартай хамтран газар дээр нь судалгаа хийж зайлшгүй шаардлагатай 19, 18, 16, 7 дугаар хороонд цахилгааны хүчдэл сайжруулах шугамын зураг төсвийг нийслэлийн төсвөөр хийгдэхээр батлагдан зураг төслийн ажлын тендерт “Электро Сэт Проект” ХХК шалгаран гүйцэтгэж дууссан.	100
59	3.2.3. Гэр хороод болон	121	1.Дүүргийн гэр хороод болон	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 19	100

	нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, камерын тоог нэмэгдүүлнэ.		нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, камерын тоог нэмэгдүүлнэ.	дүгээр хороонд “И энд Си Инженеринг” ХХК 62,6 сая төгрөгөөр 40ш гэрэлтүүлэг, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Баян дөрвөлж” ХХК 190 сая төгрөгөөр 132ш гэрэлтүүлэг, Дүүргийн төсвийн хөрөнгөөр “Лед Сити” ХХК 79,8 сая төгрөгөөр 76 ширхэг гэрэлтүүлэг, Энержи комплекс ХХК 10 хороодод 78,5 сая төгрөгөөр 76 гэрэлтүүлэг, “Соёндрийм” ХХК 10, 12, 16 дугаар хороодод 83,2 сая төгрөгөөр 64 гэрэлтүүлэг, “Их цамхаг хүрээ” 4, 19 дүгээр хороонд 30 гэрэлтүүлэг нийт 416 ширхэг гэрэлтүүлэг 527,7 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн	
60	3.2.4. Орон сууцны болон гэр хороодын хаягжилтыг бүрэн шинэчилж, “Чингэлтэйн хаягжилт” загвар төсөл хэрэгжүүлнэ.	122	1. “Чингэлтэйн хаягжилт” загвар төслийг хэрэгжүүлж, зөвшөөрөлгүй хашаагаа сунгасан асуудлыг цэгцэлнэ.	“Азийн сан” болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулсан Хотын засаглалыг сайжруулах төслийн хүрээнд 12 дугаар хорооны хаягжилтыг сайжруулах иргэдийн санаачлага дээр үндэслэн судалгаа явуулж байна. Мөн 16 дугаар хороонд Хайлаастын эцсийн “Хаан банк”-тай уулзвараас баруун тийш буюу Согоотын 62, 81, 79 дүгээр гудамжинд авто зам, эко хавтан, бетонон явган зам хийгдэх ажлын хүрээнд 9 айл, 7,10 дугаар хороо, Дэнжийн 40, 41, 42, 32, 33 дугаар гудамжуудын хоорондох зам буюу Ундрам дэлгүүрийн авто замаас “Самбалхүндэв”-ийн эргэмжийн газрын авто замтай холбох ажлын хүрээнд хүрээнд 6 айл нийт 15 айл хашаагаа татаж газар чөлөөлөлт хийгдсэн.	100
61	3.2.5. Гэр хороодын иргэдийн үүсгэл санаачилга, оролцоон дээр тулгуурлан “Миний гудамж”, “Гэрэлтэй гудамж” төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн, амьдарч буй орчноо сайжруулан өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	123	1. “Миний гудамж”, “Гэрэлтэй гудамж” төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн, иргэдийн үүсгэл санаачилга, оролцоон дээр тулгуурласан санал санаачлагыг дэмжин ажиллана.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 13 дугаар хорооны 17дугаар сургуулийн арын зам буюу 9-р гудамжийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр засварлах ажлыг “Эф Өү Эм” ХХК хийж гүйцэтгээд байна. 18 дугаар хороо Хандгайтын 12,14 гудамжийг тохижуулах ажлыг “Санборст” ХХК 480м2 явган хашаа будах ажил хийж гүйцэтгэсэн.19 дүгээр хороо Дээд салхитын ам Эрдмийн цэцэрлэгт хүрээлэнд 161у/м байгалийн чулуун зам болон 921м2 авто зогсоолыг “Эко тогтол” 321,6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	100
		124	2. Хороодын иргэдийн бүлгийн	Гэр хороодын иргэдийн үүсгэл санаачилга, оролцоон	100

		оролцоог нэмэгдүүлэх, чадваржуулах ажлыг зохион байгуулна.	дээр тулгуурлан хороодын иргэдийн бүлгийн оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх иргэдийн бүлгийн оролцоотой хэрэгжих явган зам, тохижилтын ажлын 16 байршилд эскиз зураг, ажлыг тоо хэмжээ гаргасны дагуу гүйцэтгэл 100% хийгдэж хүлээн авсан.	
62	3.2.6. Гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган зам, шат, гүүр, ус түгээх байр барьж иргэдийн амьдрах орчныг сайжруулна.	125	1. Гэр хороодын гуу жалгатай газруудад явган зам, шат, гүүр барих ажлыг иргэдийн бүлгийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.	100
		126	2. Хүн амыг баталгаат ундны усаар хангаж, ус түгээх байруудын баталгаат нөхцөлд хяналт шалгалт хийж ажиллана.	100

				ажиллаж байна. 17 дугаар хороо Шар хагтын аманд гүний худаг гаргах ажлыг Чингэлтэй дүүргийн ТҮК хийж ашиглалтанд оруулсан.	
63	3.2.7. Алслагдсан гэр хороодын айл өрхийг нийтийн тээврийн үйлчилгээнд бүрэн хамруулж, нийтийн тээврийн чиглэл, маршрутыг уртасгах, автобусны буудлуудыг тохижуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	127	1. Алслагдсан гэр хороодын иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх, чиглэл маршрутыг уртасгах ажлыг иргэдийн санал, хүсэлтэд тулгуурлан холбогдох байгууллагад уламжлан хэрэгжүүлнэ.	Нийслэлийн хэмжээнд Нийтийн тээврийн 83 чиглэлд иргэдэд үйлчилдгээс Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг 6 байгууллага, аж ахуйн нэгжийн 49 чиглэл үйл ажиллагаа явуулж байна. Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо Чингэлтэйн эцэс хүртэл одоогийн байдлаар нэг автобус баазын "Ч23: Чингэлтэй Зүрх уул – МУБИС - Цэцэг төв" чиглэлийн 1 автобус явдаг. Уг чиглэл дээр иргэдээс гарсан саналын дагуу "Ч:24б зунжин – Гурвалжингийн гүүр – ТЭЦ4-3,4 хороолол" чиглэлийг Чингэлтэйн эцэс чиглэлийг нэмэлтээр явуулахаар Нийслэлийн тээврийн газарт 8/1207 тоот албан бичиг хүргүүлсэний дагуу 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс тухайн чиглэлд нэмэлтээр чиглэл явж эхэлсэн.	100

ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ		2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА		БИЕЛЭЛТ	ХУВЬ
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН-НОГООН ХӨГЖИЛ					
4.1 БАЙГАЛЬ ОРЧИН					
64	4.1.1. Агаарын бохирдлыг бууруулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэн, гэр хороодын айл өрхийг төвийн эрчим хүчний болон бие даасан эх үүсвэрээр хангана.	128	1. Агаарын бохирдлыг бууруулах олон талт ажлыг үргэлжлүүлэн, хувийн хэвшлийн халаалтын зуухнуудад тавих хяналтыг сайжруулж ажиллана.	Тайлант хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уурын болон усан халаалтын зуухны машинистуудад зориулсан сургалт зохион байгуулж уурын болон усан халаалтын зуухны 16 машинистууд "Үнэмлэхтэй"-тэй болгосон. Мөн зуухны галлагаа засвар үйлчилгээ, хөдөлмөр хамгаалалтын талаар хөдөлмөр аюулгүйн журам заавар зааварчилгаа өгсөн.	90
65	4.1.2. Төвийн эрчим хүчний болон бие даасан эх үүсвэрээр хангах боломжгүй айл өрхийн түүхий нүүрсний	129	1. Эрчим хүчний хэмнэлттэй, усан халаалтын болон утаагүй, дулаан баригч шинэ технологийн халаалтын зуухыг гэр хороодын айл	Нийслэлийн агаарын чанарын албанаас агаар цэвэр хороо аяны хүрээнд 7-19 хорооны айл өрхүүд төсөл бүрэн шатталтай хэрэглэж байгаа айл өрхийн бүртгэлжүүлэх нэгтгэн НАЧА хүргүүлсэн. Тусгаар	100

	хэрэглээг багасгах, нам даралтын болон бүрэн шаталтат зуух суурилуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.		өрхүүдэд нийлүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	тогтнолын талбайд “Изо Хаус” ХХК-тай хамтран Канад модон хийцтэй угсармал зөөврийн амины орон сууцны үзэсгэлэн гаргаж 3000 гаруй иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч байна. Уг ажлын хүрээнд барилгын халаалт, хөргөлт, хүлэмжийн аж ахуйн дулаан хангамжинд хэрэглэх боломжтой нарны эрчим хүчнээс дулаан, цахилгаан үйлдвэрлэх эко технологи бүхий төвийн ситемд холбогдоогүй эрчим хүчний үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрийн уурын систем, халаалтын туслах үүсвэр бий болгох төслийг дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хот байгуулалт зураг төслийн хүрээлэн ХХК-тай хамтран иргэд олон нийтэд сурталчилан танилцуулсан. Гүүдшэйрийнг ХХК-тай санамж бичигт гарын үсэг зурснаар дулаан баригч хямдралтай үнээр худалдаалах төслийн ажил хэрэгжиж эхэлсэн. Төслийн хүрээнд нийт 1500 ширхэг дулаан баригч худалдах бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд 7-19 хорооны хэсгийн ахлагчдад сургалт хийгдэж 75 хэсгийн ахлагчтай гэрээ байгуулсан. 2016-09-15-нд санамж бичигт гарын үсэг зурснаар энэ жилийн төсөл хэрэгжиж эхлэн, нийтдээ 1500 ширхэг дулаан баригч худалдаалахаар төлөвлөн ажиллаж байна.	
66	4.1.3. Ногоон хөгжлийг дэмжих замаар “Ногоон дүүрэг” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	130	1. Ногоон хөгжлийг дэмжих замаар “Ногоон дүүрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.	Хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламж, арчлалт хамгаалалтын ажлыг үе шаттайгаар хийхээр төлөвлөн эхний ээлжинд Ногоон байгууламжийн зүлэг самналт 294879 м2, усалгааны ажил 8 байршилд талбайд хувиарын дагуу хийлээ. Мөн 923 ширхэг мод, 1635 ширхэг бут, сөөг, 4659 у/м ургамлан хашлагыг тайралт, таналт, хэлбэржүүлж, 923 ширхэг улиас мод шохойдох ажлууд хийгдсэн. Мод бут сөөгний тарилтын хүрээнд Чингэлтэй хайрханы Эрдмийн цэцэрлэгт хүрээлэнд шилмүүст 310 ширхэг модоор ойжуулалтын ажил, Шар Агтын аманд шилмүүст мод 50 ширхэг, хайлаас мод 4000 ширхэг, хорооны цогцолбор байрны хашаанд 610 ширхэг мод, Нийтийн эзэмшлийн гудамж, бичил цэцэрлэгт 218ш шилмүүст мод, 2799ш амьд хашлага	100

				Сургууль цэцэрлэгийн хашаанд 58 ш шилмүүст мод, 1193ш навчит мод, 2300ш амьд хашлага, Орон сууцны хорооллын дундах талбайд 73 ш шилмүүст мод 2000ш амьд хашлага, Гэр хорооллын айл өрхийн хашаанд 856ш мод бут тарих ажлууд хийгдсэн. Үүнээс нийт шилмүүст мод 660 ширхэг/ нарс, гацуур, шинэс, Бут сөөг 5391 ширхэг, амьд хашлага 20135 ширхэг нийт 25526 ширхэг 19 төрлийн мод бут сөөг тарьсан.	
		131	2.Нийтийн эзэмшлийн гудамж талбай, сургууль, цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчилгаа, тордолгоог тогтмолжуулж, зүлэгт талбай, модны ургалтыг нэмэгдүүлнэ.	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн ногоон байгууламжийн арчилгаа, цэнэг усалгааг хариуцсан хэлтэс албадтай хамтран хийсэн. Мөн хаврын нөхөн тарилт болон шинээр мод тарих өдөрлөгт ерөнхий боловсролын 9 сургуулийн 85 багш, 78 эко сурагч, 14 цэцэрлэгийн 84 багш ажилчид, эцэг эхчүүд оролцож, нийт 6 төрлийн 58 ширхэг шилмүүс мод 268 ширхэг навчит мод бут сөөг, амьд хашлага 2300 ширхэг мод тарьсан.	100
		132	3. Сул шороон хөрс бүхий гудамж, талбайг үе шаттайгаар зүлэгжүүлэх, хатуу хучилттай болгох ажлыг зохион байгуулна.	Дүүргийн хэмжээнд сул шороон хөрс бүхий гудамж, талбайг үе шаттайгаар зүлэгжүүлэх, хатуу хучилттай болгох ажил одоогийн байдлаар нийт 16 хороодод Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 14280м2 талбайд, ОНХС-ийн хөрөнгөөр 5136м2 талбайд, Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 29277,8м2 талбайд нийт 48694м2 талбайд тус тус хатуу хучилттай болгосон.	100
67	4.1.4. Дүүрэгт мод үржүүлгийн газар бий болгоно.	133	1. Дүүргийн нутаг дэвсгэрт Мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа явуулдаг стандартын суулгац үржүүлдэг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын санал санаачлагыг дэмжин ажиллана.	Дүүргийн 19 дүгээр хороо, Гоодойн аманд байрлах Чингэлтэйн ахмадын амралтын газрын 2,3 га талбайд жимс, жимсгэний болон бусад мод, бут, суулгац тарихад хамтран ажиллахаар “Хүмүүнлэг залуусын давалгаа” ТББ, Чингэлтэй хайрханы ойжуулалтыг “Чингэлтэй дүүргийн ТҮ” ХХК-тай ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн 17-р хорооны Шар Агтын аманд нөхөн сэргээлт ойжуулалтын ажлыг эхлүүлээд байна Үүнд: хаврын тарилтын хүрээнд шилмүүст мод 50 ширхэг, хайлаас мод 4000 ширхэг тус тус тарьсан ба худаг гарган усалгааны асуудлыг бүрэн шийдэж таригдсан модны арчилгаа усалгааг 17 дугаар	100

			хорооны ахмадын хорооны дарга н.Шүрхүү хариуцан ажиллаж байна.	
68	4.1.5. Байгаль хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд иргэд, төрийн бус байгууллагын оролцоог ханган, урамшууллын тогтолцоо бий болгоно.	134	1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх, хяналт шалгалт хийх төрийн зарим чиг үүргийн ажлыг байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн нөхөрлөл, бүлгүүдээр хийлгэж, ногоон байгууламж нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах тогтолцоог бий болгон урамшуулна.	100
69	4.1.6. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн ногоон байгууламжийг арчлах, хамгаалах тогтолцоо бүрдүүлэн, байгууллага, аж ахуйн нэгжийг орчны бичил цэцэрлэг, төгөлтэй болгох, гэр хороодын хашааг моджуулах урамшуулалт хөдөлгөөн өрнүүлэн ажиллана.	135	1. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн ногоон байгууламжийг арчлах, хамгаалах тогтолцоо бүрдүүлэн, байгууллага, аж ахуйн нэгжийг орчны бичил цэцэрлэг, төгөлтэй болгох урамшуулалт хөдөлгөөн өрнүүлж, иргэн аж ахуйн нэгж байгууллагыг ногоон байгууламжийг арчлах, ургуулах арга зүйгээр ханган ажиллана.	100
70	4.1.7. Гэр хороодод хиймэл нуур, усан сан бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн тав тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.	136	1. Гэр хороодод тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, арчлалт, хамгаалалтын талаарх иргэдийн санал санаачилгыг дэмжин ажиллана.	100

				модоор тарилт хийгдсэн. Мөн ТҮК 1-19 дүгээр хорооны 26 бичил цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчилгаа, цэвэрлэгээ тогтмол хийгдэж байна. Ногоон байгууламжийн өвөлжилтөд бэлтгэж цэнэг усалгаа, навч хогийг цэвэрлэх, цасаар хучих ажлууд хийгдсэн.	
71	4.1.8. Чингэлтэй хайрхан, Сэлбэ голын ай сав газарт “Эко бүлэг” ажиллуулан, ойжуулалтын ажлыг үргэлжлүүлэн хийх ба нутаг дэвсгэрийн булаг шандыг хамгаалалтад авна.	137	1. Чингэлтэй хайрхан, Сэлбэ голын ай сав газарт “Эко бүлэг” ажиллуулан, ойн нэгдсэн сангийн мэдээллийг сайжруулж, ойжуулалтын ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	Чингэлтэй Хайрхан уулын ойжуулалтын ажлыг үргэлжлүүлэн хийж, урьд жилүүдэд таригдсан 4 төрлийн мод бутанд усалгаа хуваарийн дагуу хийж налсан, хазайсан үндэс нь ил гарсан модыг тэгшилж сэргээсэн. Мөн 2500-аас доошгүй мод таригдах модны нүхний тоог гаргаж, мод тарьсан. Үүнд: Чингэлтэй хайрхан ууланд 2 төрлийн 9-12 насны 1,2-2 м өндөр 270 ширхэг шинэс, гацуур гэсэн шилмүүст модоор нөхөн сэргээлтийн ажил, шар Агтын аманд 50 шилмүүст мод 4000 ширхэг хайлаас мод тарьж арчилгаа усалгааг Чингэлтэй дүүргийн Тохижилт Үйлчилгээ ХХК хийж гүйцэтгэж байна. Мөн Нийслэлийн Байгаль орчин ногоон хөгжлийн газартай хамтран Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын “Эко клуб”-ийн гишүүдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, урамшуулах зорилгоор эрдэм шинжилгээний байгууллагууд болох Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, Од, эрхэс судлалын төв (Астро парк), Одон орон геофизикийн хүрээлэн (Хүрэл тогоот), байгууллагуудаар танилцах аялалыг зохион байгууллаа.	100
		138	2. Дүүргийн нутаг дэвсгэр дэх булаг шандыг хамгаалалтад авах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	Дүүргийн 7-р хорооны хувьсгалчдын Г-ийн 12 дугаар гудамжны тохижилт хийгдэж дуусан. Жигжид, Ар согоот зуслангийн орчим рашаан булгийн эх хамгаалах, тохижуулах ажлын зураг тендер зарлан LAID групп ХХК гэрээ байгуулан зураг төслийн ажил хийгдэн зургийн дагуу хөрс хуулалтын ажил хийгдэн үргэлжилж байна. Мөн Дүүргийн 18 дугаар хорооны Чингэлтэй Хайлаастын зам дагуух булгийн эх хамгаалах, орчныг тохижуулах ажлын зураг төсөл хийгдэж дуусан ирэх онд хийгдэнэ.	100

4.2 Хог хаягдал, хөрсний бохирдол

72	4.2.1. Хөрсний бохирдлыг бууруулан, гэр хороодын айл өрхийг бохирын төвлөрсөн шугамд холбох, хэсэгчилсэн инженерийн шугам сүлжээ бий болгох ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	139	1. Гэр хорооллын айл өрхийг бохирын төвлөрсөн шугамтай холбох, хэсэгчилсэн инженерийн шугам сүлжээ бий болгох ажлыг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.	Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны хамтарсан 1 тэрбум төгрөгний санхүүжилтээр хэрэгжиж байгаа Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд Сэлбэ дэд төв дээр 2.2 км бохирын шугамын ажлыг “Хүрд” ХХК, “Зэст Хөлөг” ХХК 7 буудлаас Хайлаастын замын уулзвар хүртэл 14, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт төв замын баруун талаар бохирын цооног хийх ажил хийгдсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Нуурын 18 дугаар гудамжны нийтийн байранд бохирын цооног хийх ажлыг “Энэрэлт эх эрдэнэ” ХХК хийж гүйцэтгэсэн.	100
73	4.2.2. Нийтийн бие засах газрын тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	140	1. Хүн амын төвлөрөл ихтэй газруудад байрлуулсан сайжруулсан ариун цэврийн байгууламжийн ашиглалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллана.	Дүүргийн нутаг дэсгэрт нийтийн сайжруулсан ариун цэврийн байгууламж “Сити тоелет” 4 байршилд байгуулагдсан бөгөөд 2015 онд 15,17-р хороодын нутаг дэвсгэрт “Сити тоелет” нийтийн бие засах газрыг Улсын комисст хүлээлгэн НҮУБН ОНӨААТҮГазар ашиглалтыг хариуцан дүүргээс хяналт тавин ажиллаж байна. Нийслэлийн хөрөнгөөр дүүргийн 19 дүгээр хорооны Шадивлан зусланд 5 ширхэг нийтийн бие засах байгууламж барьж ашиглалтанд оруулан тус байгууламжийн эвдрэл гэмтэлд хяналт тавин ажиллаж байна. Мөн 2016 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр зуслангийн бүсэд Яргайтын богино, Майхан толгойн зуслангийн амуудад нийтийн бие засах газар байгуулахаар байршлыг тодорхойлж, “Four L” ХХК шалгаран 38.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн.	100
		141	2. Гэр хорооллын болон зуслан, ногоон бүсийн айл өрхийн жорлон, муу усны нүхийг ариутган, хөрсийг халдваргүйжүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд айл өрхийн бохирын цооног, бие засах газрыг ариутгал хийлгэх санал хүргүүлсний үр дүнд 2016 онд зуслангийн ногоон бүсийн айл өрхийн бохирын цооног, хогийн цэг, нийтийн бие засах газруудын ариутгал, халдваргүйжүүлэх ажилд “Гантуяа” ХХК шалгаран, хийж гүйцэтгэсэн.	100

74	<p>4.2.3. Хөрсний элэгдэл, эвдрэлд орсон газрууд, үерийн далан суваг, борооны ус зайлуулах шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, сэргээн засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>	142	<p>1. Борооны ус зайлуулах шугам сүлжээ, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн арчлалт, хамгаалалт, цэвэрлэгээг тогтмол хийж хэрэгжүүлнэ.</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2016 оны А/41 дүгээр захирамжийн дагуу бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулж, дүүргийн хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд хамтран ажиллах гэрээний үүргийн дагуу хог цэвэрлэгээний иргэдийн бүлгийг ажиллуулж борооны ус зайлуулах шугам сүлжээ, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн арчлалт, хамгаалалт, цэвэрлэгээг тогтмол хийлгэж хяналт тавин ажиллалаа. Тус ажлын хүрээнд батлагдсан хуваарийн дагуу тайлант хугацаанд 6 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгууллаа. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны шийдвэрээр 2016.04.01-ний өдрөөс эхлэн гэр хорооллын нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ажиллах иргэдийн бүлгийн санхүүжилтийн асуудлыг шийдэж өгснөөр дүүргийн нутаг дэвсгэрт нийт 13 иргэдийн бүлгийн 100 гаруй ажилчид тогтмол цэвэрлэгээний ажилд хамрагдлаа. Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжид энэ онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу НҮУБН ОНӨААТҮГазар 8 гол үерийн хамгаалалтын далан сувгийн цэвэрлэгээг хариуцан гүйцэтгэсэн. Мөн Дэнжийн 1000-ын 1, 3 дугаар сувгийн булгийн мөсийг ухах, халиа үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.</p>	100
75	<p>4.2.4. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгон, хог ачих, зайлуулах үйлчилгээнд тавих хяналтын бүтэц бий болгож, ЭКО эргүүл ажиллуулсан, хур хог үүсэх явдлыг таслан зогсооно.</p>	143	<p>1. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгон хог ачих, зайлуулах үйлчилгээнд тавих хяналтыг иргэдийн ороцоотойгоор гүйцэтгэж ажиллана.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын А/710, дүүргийн Засаг даргын А/306 дугаар захирамжийн дагуу 14 иргэнийг тохижилт, хог хаягдлын Олон нийтийн байцаагчаар томилон ажиллуулсан. Тус ажлын хүрээнд хороо тус бүрд хог тээвэрлэлт, зам талбайн цэвэрлэгээ, аж ахуйн нэгж байгууллагуудын тохижилт, цэвэрлэгээний үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Тохижилт, хог хаягдлын чиглэлээр хөндлөнгийн хяналтын үүрэг гүйцэтгэж буй Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны гэрээт ЭМНБХүрээлэн ТББ, дүүргийн гэрээт Урагш дэвших холбоо ТББ-ууд дүүргийн нутаг дэвсгэрт тогтмол хяналт тавин чиг үүргийн дагуу мэдээлэл өгч</p>	100

			арга хэмжээ авч ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 6 үүсмэл хогийн цэгийг устгах арга хэмжээ авч ажилласан.	
	144	2. Хог хаягдал, орчны бохирдлын талаарх иргэдийн мэдлэг, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулна.	Хог хаягдлын чиглэлээр иргэдийн мэдлэг, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд хөндлөнгийн хяналтын ТББ-ууд болон хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудтай хамтран нийт 5 удаагийн уулзалт сургалтыг 2, 3, 12 дугаар хороодын иргэд, аж ахуйн нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, холбогдох албан хаагчдыг хамруулан зохион байгууллаа. Тохижилт, хог хаягдлын Олон нийтийн байцаагч нарыг чадавхижуулах сургалтыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, “Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн” ТББ-тай хамтран 2 удаагийн уулзалт сургалтыг зохион байгуулсан.	100

ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЕЛЭЛТ	ХУВЬ
--	------------------------------------	---------	------

ТАВ. ХЯНАЛТТАЙ ОРЧИН-НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ

5.1 НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ

76	5.1.1. Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй, ил тод байдлыг ханган, “Цахим засаглал”-ыг хөгжүүлэх замаар “Нээлттэй дүүрэг” болно.	145	1. Нутгийн удирдлагын болон захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй ажлыг олон нийтэд сурталчлан, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын www.chingeltei.gov.mn цахим хуудсанд нийт 577 мэдээ, мэдээлэл байршуулсан ба “Энх-Арслан” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан арга хэмжээг олон нийтэд мэдээлж байна. Гэрээний дагуу дүүрэгтэй холбоотой мэдээ Арслан.мн, Засаг.мн сайтад тавигдсан байна. Тайлант хугацаанд фэйсбүүк хуудас 3116 лайктай, твиттер хуудасны 7 хоногийн хандалтын тоо 28000-48000 хооронд хэлбэлзэж байна. “UBS” телевиз, дүүргийн Засаг даргын Тамгын газрын хамтын ажиллагааны хүрээнд өрнүүлсэн “Хүүхдийн номын өргөөг номжуулах аян”-ны хугацаанд цуврал нэвтрүүлгүүд бэлтгэн, эхний гурван цуврал	100
----	---	-----	--	--	-----

			<p>нэвтрүүлгийг хүлээн авч архивлаад байна. “МНС” телевизтэй хамтран орон нутгийн төр, захиргааны байгууллагаас хийж хэрэгжүүлсэн ажлыг тайлагнах “Дүүргийн сар аян”-ыг өрнүүлж, мэдээллийн хөтөлбөрөөр дүүргийн ажлын тухай 9 мэдээ, 5 нэвтрүүлэг, 5 удаагийн шууд нэвтрүүлэг хийсэн. ТВ5, ТВ9, ETV, Стар зэрэг тв-ээр дүүргийн холбогдолтой мэдээ мэдээллүүд олон нийтэд хүргэж ажилласан.</p>	
	146	<p>2. Хороодын утасгүй интернетийн бүс, цэгийн үйл ажиллагааг сайжруулах, өргөтгөх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.</p>	<p>Дүүргийн хороодын дотоод сүлжээг шинэчлэх ажлын хүрээнд 1, 5, 9, 10, 15, 17 дугаар хороодын утасгүй интернетийн бүсийн тасралтгүй ажиллагааг сайжруулан ажиллалаа. Хороодын утасгүй интернетийн бүсийн үйл ажиллагааг өргөтгөн хорооны 200 метр орчмын бүсэд утасгүй түгээх ажлыг нийслэлийн мэдээлэл технологийн газартай хамтран зохион байгуулж байна.</p>	100
	147	<p>3. Хороодын үйл ажиллагааг “Эрүүл, аюулгүй байдлын индекс”-ээр дүгнэн урамшуулан ажиллана.</p>	<p>Эрүүл аюулгүй байдлын индексийн хэрэгжилтийг сайжруулах, анхан шатны маягт хөтлөлтөд хяналт үнэлгээ хийх зорилгоор Засаг даргын Тамгын газрын даргын батлагдсан удирдамжийн дагуу хороодод 2016.04.21-нээс 27-ний өдрүүдэд хяналт үнэлгээ хийж, ЭАБИ-тэй холбоотой мэдээ, мэдээллийг цуглуулах арга аргачлал, анхаарах асуудлууд сэдвээр сургалт зохион байгуулж нийт 174 хэсгийн ахлагч нарыг хамруулсан. Нийслэлийн Засаг даргын шилдэг хороо шалгаруулах болзолт уралдаан, ЭАБИ-ийн зөвлөх багаас дүүргүүдийн хэмжээнд ЭАБИ-ийн мэдээ мэдээллийг цуглуулах явцад тулгамдаж буй асуудлыг олж илрүүлэх, мэдээллийн үнэн бодит байдлыг хангуулах зорилгоор хийгдсэн хяналт үнэлгээнд дүүргийн 1-19 дүгээр хороод хамрагдаж өгсөн зөвлөмжийн дагуу мэдээллийг ахин нягтлан гаргах ажлыг зохион байгууллаа. Дүүргийн ЭАБИ хариуцсан нийгмийн ажилтан нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө 3 удаа өгч хамтран ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтсүүдэд 2015 оны</p>	100

			мэдээлэл ирүүлэх, 2016 оны Эрүүл аюулгүй байдлын индексийн хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг авч нэгтгэн төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллалаа.	
	148	4. Монгол Улсын хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах ажлыг эрчимжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль эрх зүйн анхан шатны зөвлөгөө, өмгөөллийн туслалцаа үзүүлнэ.	Тайлант хугацаанд төлбөрийн чадваргүй 150 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй 21 иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын болон Улсын бүртгэлийн тухай хуулиудын үзэл баримтлал, ач холбогдол, эрх зүйн актуудын амьдралд хэрэгжих үндэслэл зэрэг агуулгаар дүүргийн ЗДТГ болон хороодын албан хаагч, хороодын иргэний танхимаар дамжуулан хууль эрх зүйн сургалтыг холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулж нийт 1200 гаруй иргэдийг хамруулсан байна. Энэ тухай мэдээллийг дүүргийн цахим хуудас болон 1-19 дүгээр хороодын иргэний танхимийн “facebook” хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажиллалаа.	100
	149	5. Дүүргийн цахим хуудсаар ЗДТГ-ын үйл ажиллагаа болон төрийн үйлчилгээний талаар санал асуулга явуулж бодлого шийдвэрт тусган ажиллана.	Дүүргийн цахим хуудсаар Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа болон төрийн ажил, үйлчилгээний чиглэлээр 2 төрлийн санал асуулга явууллаа. Санал асуулгаар Та дүүргийн ажилтануудын мэдлэг ур чадварыг хэрхэн дүгнэх вэ? гэсэн асуултанд санал өгсөн иргэдийн 73,5 хувь нь хангалттай үнэлгээ өгсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар өссөн сайн үзүүлэлттэй байна. Мөн та дүүргийн тохижилт, бүтээн байгуулалт, ногоон байгууламжийн ажлыг дүгнэнэ үү? гэсэн асуулгад санал өгсөн иргэдийн 96.5 хувь нь хангалттай үнэлгээ өгсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Дүүргийн цахим хуудсанд Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, алба, хороодын хагас жилийн үйл ажиллагааны тайланг байршуулж, тайлан тус бүрд иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч	100

			дүгнэлт хийж ажиллалаа.	
	150	6. Нутгийн захиргааны байгууллагаас иргэдэд ажлаа сурталчлах, тайлагнах зорилгоор “Ажлаа танилцуулах өдөрлөг” зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2016 оны А/9 тоот захирамжаар Нийгмийн даатгалын хэлтсээс “Нээлттэй хаалганы өдөр-Нэг цонхны үйлчилгээ” өдөрлөгийг хуваарийн дагуу зохион байгуулж дүүргийн 7-11 дүгээр хороодын иргэдийг оролцуулан 2016.02.18-ны өдөр 9 дүгээр хорооны иргэний танхим, 11-15 дугаар хороодын иргэдийг оролцуулан 2016.03.10-ны өдөр 14-р хорооны иргэний танхимд 2 удаа зохион байгуулж 126 иргэнийг хамрууллаа. Дүүргийн Засаг даргын А/316 дугаар захирамжийн дагуу “Бид сайн сайханд дагуулна” өдөрлөгийг 2016.05.22-ны өдөр зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үеэр соёл урлагийн их сургуулийн өмнөөс Тусгаар тогтнолын талбай хүртэл 1000 гаруй иргэд парад алхсан. Өдөрлөгөөр нийт 10,0 мянга гаруй иргэнд соёл урлагийн олон талт үйл ажиллагаа, төрийн үйлчилгээ, мэдээ, мэдээлэл хүргэн ажиллалаа.	100
	151	7. Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлэн, бодлогын баримт бичиг боловсруулан, гадаад орнуудын сайн туршлагыг нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Тайлант хугацаанд Бүгд Найрамдах Турк Улсын Анкара хотын Синжан дүүргийн Засаг дарга Мустафа Тунагийн урилгаар Анкара, Истамбул хотуудын хот төлөвлөлт, дахин төлөвлөлтийг газар дээр нь очиж танилцах, туршлага судлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор дүүргийн Засаг дарга болон хороодын Засаг дарга нар 2016.01.14-01.20-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Турк Улсын Анкара, Синжан дүүргүүдэд айлчлал хийж улмаар Бүгд Найрамдах Турк Улсын Анкара хотын Синжан дүүргийн Хот дахин төлөвлөлтийн газрын дарга Өнал Баяр, Төслийн газрын дарга Гүнэш Каплан нар 2016.02.16-02.20-ны өдрүүдэд Чингэлтэй дүүрэгт ажлын айлчлал хийж, туршлага солилцлоо. ОХУ-ын Буриад Улсын Улаан-Үд хотын Советский дүүргийн ерөнхий боловсролын 1 дүгээр дунд сургуультай дүүргийн 39 дүгээр дунд сургууль хамтран ажиллах гэрээ байгуулсан ба Оросын Холбооны Улсын САХА-Якутск Улсын Хангаласский дүүрэгт Чингэлтэй дүүргийн ерөнхий	100

